



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАЛААЛТЫН ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ”

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын түлш халаалтын зардлыг
эдийн засгийн тооцоо судалгаанд үндэслэн
төлөвлөх шаардлагатай байна.

Аудитын код: ДГА-2021/76-ШТА-ГА

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг
2021 оны 06 сар

Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч:	Т.Ган-Өлзий
Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор:	Э.Энхцэцэг
	Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn
Аудитор:	Ч.Хэрлэнчимэг
	Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn
Аудитор:	Б.Ариунбаатар
	Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn

	ТАЙЛАНГИЙН АГУУЛГА
<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Агуулга 2
Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгийн тайлбар 3 Хүснэгтийн товъёог 4
Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Дүрслэлийн товъёог 4 Хавсралтын товъёог 5 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 6-7 Ерөнхий мэдээлэл 8
Т.Ган-Өлзий	
Аудитын менежер	БҮЛЭГ А. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА БОЛОН СТСХ ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО СУДАЛГААГ ҮР ДҮНТЭЙ ХИЙХГҮЙ БАЙГААГААС ТҮЛШ, ХАЛААЛТЫН ЗАРДЛЫН ТӨСВИЙГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.
У.Оюунтүлхүүр	
Ахлах аудитор: Э.Энхцэцэг	
Аудитор: Ч.Хэрлэнчимэг	
	А.1. ЭХЗЗ нь орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байна 9-12
	А.2. Төсөвт байгууллагуудын түлш халаалтын зардлыг тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөх шаардлагатай байна. 13-16
Аудитор: Б.Ариунбаатар	
2021 оны 06 сарын 30	БҮЛЭГ Б.ТҮЛШ ХАЛААЛТЫН ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙГАА Ч ТОДОРХОЙ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛСНААР ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ БОЛОМЖ БАЙНА.
	Б.1. Түлш халаалтын зардлын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, тайлан, мэдээнд гүйцэтгэлийг үнэн зөв тусгах шаардлагатай байна. 17-23
	Б.2. Халаалтын талбайн бодит хэмжээ болон нүүрсний хэрэгцээ шаардлагыг зөв тогтоосноор төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх боломж байна. 24-33
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70522734, 70503020 дугаарын утас, dornogovi@audit.gov.mn хаягаар харилцана уу.	Аудитын дүгнэлт 34 Аудитын зөвлөмж 35-36 Холбогдох байгууллагын санал 37-38 Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар 38 Аудитын тайлан баталгаажуулсан тушаал 39-40
ХАЯГ:Дорноговь аймаг, Сайншанд сум, Төрийн өмчийн III байр.	

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол улс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
БТСГ	Биеийн тамир, спортын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
СЯ	Сангийн яам
СС	Сангийн сайд
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХЗЗ	Эрчим хүчний зохицуулах зөвлөл
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг
БАҮ	Барилга ашиглалт үйлчилгээ
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ДГА	Дорноговь аймаг
ШТА	Шууд тайлагналын аудит
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ЭЗ	Эдийн засаг
БМ	Бараа материал

Хүснэгтийн товъёог:

Утга	Тайлбар
Хүснэгт №1	ЭХЗЗ-ийн тусгай зөвшөөрөл олгосон тогтоолын судалгаа
Хүснэгт №2	ЭХЗХ, ЭХЗЗ-ийн дулааны үнэ тариф баталсан тогтоолын судалгаа
Хүснэгт №3	ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2019, 2020 оны төсвийн төсөл, гүйцэтгэлээр халаалтын талбайн харьцуулалт
Хүснэгт №4	Төсвийн төсөөлөл болон зардлын бодит зарцуулалтаар халаалтын талбайн хэмжээ
Хүснэгт №5	ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын түлш халаалтын зардлын 2019, 2020 оны төсвийн төсөл, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийн харьцуулалт
Хүснэгт №6	Түлш халаалтын зардлын төлөвлөсөн дүнг бодитоор гарахаар тооцоолсон зардалтай хийсэн харьцуулалт
Хүснэгт №7	Төлөвлөлт, батлагдсан зардлын харьцуулалт
Хүснэгт №8	Түлш, халаалтын зардлын гүйцэтгэл /байгууллагын төрлөөр/
Хүснэгт №9	Төсвийн гүйцэтгэлийн тайланд зөрүүтэй илэрхийлсэн түлш, халаалтын зардлын гүйцэтгэл
Хүснэгт №10	Түлш халаалтын төлбөр болон бусад зардал хооронд гүйлгэн зарцуулсан зардал
Хүснэгт №11	Түлш халаалтын зардлын төсвийн хэтрэлт, хэмнэлтийн зөрүү
Хүснэгт №12	Түлш, халаалтын зардлын төсөв, гүйцэтгэл /байгууллагын төрлөөр/
Хүснэгт №13	Түлш халаалтын өр төлбөр, авлагын үлдэгдэл
Хүснэгт №14	Төсвийн зориулалт бус зарцуулалт
Хүснэгт №15	Сумдын түлээ, нүүрсний зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэл
Хүснэгт №16	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй сумдын нүүрсний худалдан авах ажиллагаа зохион байгуулах төрөл
Хүснэгт №17	Бараа материалын тайлангаарх 2019, 2020 оны түлээ нүүрсний зарцуулалт
Хүснэгт №18	Түлээ нүүрсний зардлын төсвийн төсөөлөл, батлагдсан төсөв, гүйцэтгэлийн харьцуулалт
Хүснэгт №19	БМ-ын тайлангаарх 2019, 2020 оны түлээ нүүрсний зарцуулалтын харьцуулалт
Хүснэгт №20	БМ-ын тайлангаарх түлээ нүүрсний үлдэгдэл, зарцуулалтын харьцуулалт
Хүснэгт №21	Төвлөрсөн халаалтад холбогдсон сумдын түлээ нүүрсний үлдэгдэл
Хүснэгт №22	Сумдын төсөвт байгууллагуудыг галлагаагаар халаах болон төвлөрсөн дулаанд холбоход гарах зардлын тооцоо
Хүснэгт №23	Түүвэрт хамрагдсан байгууллагуудын дулааны талбайн харьцуулалт

Дүрслэлийн товъёог:

Утга	Тайлбар
График №1	Аймгийн ИТХ-аар баталсан халаалтын зардлын харьцуулалт
График №2	Халаалтын талбай болон худалдан авсан нүүрсний хэмжээ
График №3	Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийн зардлын ангилал

Хавсралтын товъёог

Утга	Тайлбар
Хавсралт №1	Талбайн хэмжээний харьцуулалт
Хавсралт №2	Төсвийн төсөөллийн дүн, өмнөх оны гүйцэтгэлийн харьцуулалт
Хавсралт №3	Төсвийн төсөөллийн дүн, зардлын бодит гүйцэтгэлийн харьцуулалт
Хавсралт №4	Төсвийн төсөл, ИТХ-аар батлагдсан дүнгийн харьцуулалт
Хавсралт №5	Үндэслэлтэй төлөвлөөгүй төсвийг баталснаас үүссэн хэмнэлт
Хавсралт №6	ХАА-ны төрөл
Хавсралт №7	Түлээ нүүрсний зарцуулалтын өсөлт, бууралт
Хавсралт №8	Төвлөрсөн дулаанд холбоход гарах зардлын тооцоолол

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөг үндэслэн “Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл”-д гүйцэтгэлийн аудит хийсэн.
Аудитын зорилт	Төсөвт байгууллагуудын түлш, халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд өөрийн санаачилгаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: - Түлш, халаалтын зардлын төлөвлөлт үр нөлөөтэй байгаа эсэх - Түлш, халаалтын зардлын зарцуулалтын үр дүнтэй байдал
Аудитын хамрах хүрээ	Аудитад ТЕЗ-ийн харьяа болон ТЗШ-ийн нийт 106 байгууллага, дулаанаар хангагч 4 аж ахуйн нэгж, байгууллага, Эрчим хүчний зохицуулах зөвлөл, Санхүүгийн хяналт, аудитын алба, Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2019, 2020 оны холбогдох үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын хязгаарлалт	Улс даяар тархаад байгаа Covid-19 цар тахал өвчлөлийн улмаас хөдөөгийн сумдаас түлш халаалтын зардлын зарцуулалттай холбоотой анхан шатны баримтуудыг цахимаар авч, холбогдох ажилтнуудтай утсаар мэдээлэл солилцон, тайлбар тодруулга авсан, мөн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын барилга, байгууламжийн халаалтын талбайн бодит хэмжээг газар дээр нь очиж үзэх боломжгүй нөхцөл байдлаас шалтгаалж Замын-Үүд, Улаанбадрах, Сайншанд сумдын зарим байгууллагуудаас түүвэрлэн хэмжилт хийж ажиллалаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС-ын Стандартын хорооноос АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан МУ-ын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, МУ-ын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “ТАБ-аас аудит хийх журам”, гүйцэтгэлийн аудитыг хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, тодруулга авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

**Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ган-Өлзий хянан удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Ч.Хэрлэнчимэг, гэрээт аудитор Б.Ариунбаатар нар гүйцэтгэв.

Аудитыг 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс эхэлж, тайланг 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор нэгтгэн, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар оруулан дуусгавар болгож, дарга, тэргүүлэх аудиторын 2021 оны 06 дугаар сарын -ны өдрийн А/... дугаар тушаалаар баталгаажуулан, Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл

Аудит хийх багийн бүрэлдэхүүнд дулаан хангамжийн чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн боловсон хүчин байхгүй, ГХБХБГ, Чандмань Илч, Чандмань бадрал ОНӨХХК-иудад халаалтын талбайг тогтоох эрх, үүрэг хууль, журмаар олгогдоогүй тул аудитаар барилга, байгууламжийн бодит талбайг оновчтой байдлаар тогтооход бэрхшээлтэй байсан.

Аудитад хамрагдагч байгууллагуудаас дулаан хангагч аж ахуйн нэгжүүдээс дулааны төлбөр нэхэмжилсэн болон төсвөөс шилжүүлсэн дулааны төлбөр, түлш, халаалтын зардлын авлага, өглөгийн талаар судалгааг гаргуулж албан бичгээр авсан. Гэвч судалгаа болон шаардлагатай баримт материалыг цаг хугацаанд ирүүлэхгүй байх, ирүүлсэн судалгаанд тусгагдсан тоон мэдээлэл анхан шатын баримт материалд тусгагдсан дүнгээс зөрүүтэй, тоон мэдээллийг баталгаажуулахгүй ирүүлэх, тайлбар болон судалгааг дахин засварлуулах зэрэг хүндрэл бэрхшээлтэй байсан.

Ерөнхий мэдээлэл:

Аймгийн ТЕЗ-ийн харьяа болон ТЗШ-ийн нийт 103 байгууллагын халаалтын зардалд 2019 онд 4,997.8 сая төгрөгийн төсөв батлагдаж, төсвийн гүйцэтгэлийн тайланд 4,846.3 сая төгрөгийг зарцуулан, 151.5 сая төгрөгийн хэмнэлттэй, 2020 онд 104 байгууллагын 6,208.8 сая төгрөг батлагдаж, 5,632.9 сая төгрөгийг зарцуулан, 575.9 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын байр ашиглалтын зардал, тухайлбал цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, түрээс, урсгал засварын зардлыг орон нутаг бүрэн хариуцдаг тогтолцоонд шилжиж, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэхээр ТЕЗ-ийн төсвийн төсөлд тусган батлуулсан байна.

Аймгийн ИТХ-аар батлагдсан орон нутгийн төсвийн түлш халаалтын зардалд ТЗШ-ийн байгууллагуудын зардлын эзлэх хувийг авч үзвэл 2019 онд 3,701.0 сая төгрөг буюу 74.1 хувь, 2020 онд 4,340.3 сая төгрөг буюу 69.9 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутгийн төсвөөс 2019 онд ТЕЗ-ийн харьяа 103 байгууллагын түлш халаалтын зардлыг санхүүжүүлсэн бөгөөд үүний 62 хувь буюу 65 байгууллага, 2020 онд нийт 104 байгууллагаас 87 байгууллага буюу 82.1 хувь нь төвлөрсөн халаалтад холбогдсон байна.

Төсөвт байгууллагуудын дулааны эрчим хүчээр хангагдсан байдал

Д/д	Он	Төвлөрсөн халаалтад холбогдсон	Түлш түлдэг	Нийт байгууллагын тоо
1	2019	64	39	103
2	2020	85	19	104

Аймгийн хэмжээнд дулаанаар хангах тусгай зөвшөөрөл бүхий Чандмань-Илч ОНӨХХК Сайншанд, Иххэт, Даланжаргалан, Айраг, Алтанширээ, Хатанбулаг, Өргөн сумдыг, Чандмань бадрал ОНӨХХК Замын-Үүд сумыг, Барилга ашиглалт, үйлчилгээний III анги Сайншанд сумын 4, 7 дугаар багт харьяалагдах байгууллагуудыг, СИЗУ ХХК Эрдэнэ, Улаанбадрах сумдын төсөвт байгууллагуудыг тус тус дулаанаар ханган ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд Хөвсгөл, Сайхандулаан, Мандах, Дэлгэрэх сумд төвлөрсөн дулаанд холбогдоогүй байна.

Аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл нь МУ-ын Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан, 3 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

А. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА БОЛОН СТСХ ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО СУДАЛГААГ ҮР ДҮНТЭЙ ХИЙХГҮЙ БАЙГААГААС ТҮЛШ, ХАЛААЛТЫН ЗАРДЛЫН ТӨСВИЙГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

А.1. ЭХЗЗ нь орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байна.

А.1.1. Хууль, журамд заасан шаардлагуудыг бүрэн хангаагүй аж ахуйн нэгж байгууллагад тусгай зөвшөөрөл олгосон байна.

Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тусгай зөвшөөрөл олгох эрх, үүргийн талаар МУ-ын Эрчим хүчний тухай хуулийн 11.3.1-т “Аймгийн зохицуулах зөвлөл нь энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрх, үүрэгтэй”, 12.4-т “Энэ хуулийн 12.2,12.3-т зааснаас бусад тусгай зөвшөөрлийг аймгийн зохицуулах зөвлөл олгоно” гэж тус тус заасан.

Дээрх заалтад заасан эрх үүргийн дагуу аймгийн зохицуулах зөвлөл нь аудитад хамрагдсан хугацаанд нийт 2 аж ахуйн нэгж, байгууллагад дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл олгосон байна.

ЭХЗЗ-ийн тусгай зөвшөөрөл олгосон тогтоолын судалгаа

/Хүснэгт№1

		Зөвшөөрөл хүссэн баримт		Аймгийн Зохицуулах зөвлөлийн тогтоол			
№	Дулаанаар хангагч байгууллага, аж ахуйн нэгжийн нэр	Огноо	Дугаар	Огноо	Дугаар	Агуулга	Хэрэгжиж эхлэх хугацаа
1	Чандмань бадрал ОНӨХХК	8/9/2019	1/318	11/22/2019	№05	Тусгай зөвшөөрөл олгох, түүний нөхцөл шаардлагыг тогтоох тухай	2019/11/22-2024/11/22
2	Чандмань Илч ОНӨХХК	9/17/2020	№501	12/30/2020	№06	Тусгай зөвшөөрөл олгох, түүний нөхцөл шаардлагыг тогтоох тухай /Алтанширээ, Даланжаргалан, Хатанбулаг сумд/	2020/12/30-2025/12/30

ЭХЗХ-ны 2019 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 3.1-т заасан тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргагч хуулийн этгээдийн бүрдүүлэх шаардлагатай баримт бичиг, бусад материалыг тусгасан.

Аймгийн Зохицуулах зөвлөл нь дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх тусгай зөвшөөрлийг олгохдоо хүсэлт гаргагч Чандмань бадрал, Чандмань Илч ОНӨХХК-иуд тэмдэгтийн хураамж төлсөн материал, гаднах орчны аюулгүй байдлыг хангах дүрс бичлэгийн техник хэрэгсэл байрлуулж цагдаагийн байгууллагын санал авах, аймгийн Засаг даргын санал, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, БО-ыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, газар эзэмших гэрчилгээ, тоног төхөөрөмжийн олон улсын болон үндэсний стандартыг хангаж байгаа тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, барилгын ажлын зөвшөөрөл, зураг төсөв, барилга ашиглалтад оруулсан баримтыг тус тус ирүүлээгүй, бүрдүүлбэл зохих материалыг дутуу ирүүлсэн байхад тусгай зөвшөөрлийг олгосон байна.

Эрчим хүчний тухай хуулийн 22.4-т “Тусгай зөвшөөрөл нь түүнийг олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно”, 21.1-т “Сонирхогч хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлөө Зохицуулах хороо буюу аймгийн зохицуулах зөвлөлд гаргана” гэж заасан.

Гэтэл ОНХО-аар 2019 онд Улаанбадрах суманд хийгдсэн төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг СИЗУ ХХК компани гүйцэтгэж, тус ажил өнөөдрийг хүртэл бүрэн дуусаагүй, ашиглалтад оруулах комисс хүлээж аваагүй байхад сумын ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ зэрэг төсөвт байгууллагууд тус компанитай дулаанаар хангах үйлчилгээ үзүүлэх гэрээг 2020.11.27-ны өдөр байгуулсан байна.

СИЗУ ХХК нь аймгийн зохицуулах зөвлөлд Эрчим хүчний тухай хуулийн заасны дагуу дулаанаар хангах тусгай зөвшөөрөл авах талаар хүсэлт ирүүлээгүй, тусгай зөвшөөрөлгүйгээр дулаан түгээх үйл ажиллагааг эрхлэн явуулсан байхад ЭХЗЗ нь Эрчим хүчний тухай хуулийн 37.2-т “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэсэн чиг үүргийг хэрэгжүүлээгүй, өнөөдрийг хүртэл арга хэмжээ аваагүй байна.

Аудитаар дээрх зөрчлийг арилгаж, хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авхуулахаар аймгийн ЭХЗЗ-д зөвлөмж хүргүүлээ.

А.1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үнэ тарифыг дулаанаар хангагч байгууллагуудын ТЭЗҮ-д үндэслэн тогтоосон байна.

ЭХЗХ нь МУ-ын Эрчим хүчний тухай хуульд заасан тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох бүрэн эрхийн хүрээнд 2014 оны 231 дүгээр тогтоолоор “Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлал”-ыг баталсан байна.

Аймгийн ЭХЗЗ нь Эрчим хүчний тухай хуулийн 11.3.3-т “Зохицуулах зөвлөлийн баталсан аргачлал, журмын дагуу харьяалах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тариф, хэрэглэгчийн үнийг батлах, шалгах, нийтлэх эрх, үүрэгтэй” гэж заасны дагуу аудитад хамрагдсан хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тариф тогтоох хүсэлтийг хүлээн авч, Чандмань Илч ОНӨХХК-ний Иххэт, Өргөн, Хатанбулаг, Даланжаргалан, Алтанширээ сумдын дулааны үнэ, Чандмань бадрал ОНӨХХК-ний дулааны тоолууртай байгууллагуудыг дулаанаар хангах үнэ, УБТЗ-ын ХНН Барилга ашиглалт үйлчилгээний III ангийн үнийг тус тус шинэчлэн баталсан байна. /Хүснэгт№2/

Харин аймгийн хэмжээнд дулаанаар хангагч тусгай зөвшөөрөл бүхий бусад байгууллага, аж ахуйн нэгжийн мөрдөж байгаа үйлчилгээний үнэ тариф баталсан байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Эрчим хүчний тухай хуулийн 12.3-т¹ гэж заасны дагуу Чандмань Илч ОНӨХХК-ний Сайншанд сумын дулаан түгээх үнийг ЭХЗХ-оос 2018 оны 276 дугаар тогтоолоор тогтоон мөрдөж байна.
- Чандмань бадрал ОНӨХХК-ний үнэ тарифыг аймгийн ЭХЗЗ-ийн 2014 оны 04 дүгээр тогтоолоор баталж, өнөөдрийг хүртэл мөрдөж байна.
- СИЗУ ХХК-ний Эрдэнэ сумын хэрэглэгчдийг дулаанаар хангах үнэ тарифыг аймгийн ЭХЗЗ-ийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлан, мөрдөж байна.

¹ “Улсын хилийг дайран өнгөрөх шугам ашиглах, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн /3.1.11-төвлөрсөн дулаан хангамж гэж дулааныг дангаар үйлдвэрлэдэг эх үүсвэрээс диспетчерийн зохицуулалттайгаар, эсхүл төв суурин газрын нийт хэрэглээний 50-иас дээш хэсгийг шугам сүлжээгээр хангах үйл ажиллагаа/ footnote зүүлт ашиглах хүрээнд энэ хуулийн 12.1.1-12.1.10, 12.1.12-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Зохицуулах хороо олгоно”

ЭХЗХ, ЭХЗЗ-ийн дулааны үнэ тариф баталсан тогтоолын судалгаа

Хүснэгт №2

/төгрөг/

№	Дулаанаар хангагч байгууллага, аж ахуйн	ЭХЗХ, АЭХЗЗ-ийн тогтоол				Батлагдсан үнэ тариф			
		Огноо	Дугаар	Агуулга	Хэрэгжиж эхлэх хугацаа	Төсөвт байгууллага	Орон сууц	1, 2-р зуухны хэрэглэгч ААНБ	3-р зуухны хэрэглэгч
1	Чандмань бадрал ОНӨХХК	11/24/2014	№04	Тариф батлах тухай	12/5/2014			1600	1400
		7/30/2020	№04	Үнэ батлах тухай /дулааны тоолууртай/	10/1/2020	170000			
2	Чандмань Илч ОНӨХХК	9/20/2018	№276	Тариф батлах тухай	1/1/2019	1188	350		
		8/9/2019	№03	Үнэ батлах тухай /Иххэт/	1/1/2020	1800			
				Үнэ батлах тухай /Өргөн/		1650			
		12/30/2020	№07	Үнэ батлах тухай /Алтанширээ/	1/1/2021	1900	600		
				Үнэ батлах тухай /Даланжаргалан/		1900	600		
				Үнэ батлах тухай /Хатанбулаг/		1900	600		
3	СИЗУ ХХК	7/31/2018	№03	Үнэ батлах тухай /Эрдэнэ/	10/1/2018	1800			
4	УБТЗ-ын ХНН Барилга ашиглалт үйлчилгээний 3 анги	12/30/2020	№05	Үнэ батлах тухай	1/1/2021	1600	460		

МУ-ын Эрчим хүчний тухай хуулийн 16.1-т “Цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд тухайн тодорхой нутаг дэвсгэрт цахилгаан, дулаан түгээх үйл ажиллагаа явуулах эрх олгоно”, 27.1-т “Хангагчаас үзүүлж байгаа үйлчилгээний үнийг жил бүр, тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдол бүрд хянана” гэж заасан байна.

Гэтэл СИЗУ ХХК Улаанбадрах суманд дулаанаар хангах тусгай зөвшөөрөл олгогдоогүй, үнэ тариф тогтоох хүсэлтийг аймгийн ЭХЗЗ-д хүргүүлээгүй байтал батлагдаагүй үнэ тарифыг үндэслэн 1м³ талбайг дулаанаар хангах үнийг 1980 төгрөгөөр тооцож сумын төсөвт байгууллагуудтай үйлчилгээ үзүүлэх гэрээг 2020 оны 11 дүгээр сараас байгуулсан байна.

Мөн Чандмань Илч ОНӨХХК-ний Алтанширээ, Даланжаргалан, Хатанбулаг сумдын хэрэглэгчдийг дулаанаар хангах үнэ тарифыг ЭХЗЗ-ийн 2020.12.30-ны өдрийн 07 дугаар тогтоолоор тогтоосон байна. Гэтэл дулаанаар хангагч байгууллага тариф батлагдаагүй байх хугацаанд дээр дурдагдсан сумдын төсөвт байгууллагуудтай дулаанаар хангах гэрээг 2020.10.01-ний өдрөөс эхлэн байгуулсан байна.

А.1.3. Аймгийн ЭХЗЗ нь дулааны эрчим хүчний асуудлаар орон нутагт хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

МУ-ын Эрчим хүчний тухай хуулийн 11.3.2-т “ЭХЗЗ нь тухайн орон нутагт олгосон тусгай зөвшөөрлийнхөө нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хянах”, 11.3.3-т “Зохицуулах зөвлөлийн баталсан аргачлал, журмын дагуу харьяалах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тариф, хэрэглэгчийн үнийг батлах, шалгах,

нийтлэх эрх, үүрэгтэй”, 27.1-т “Зохицуулах хороо, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь хангаагчаас үзүүлж байгаа үйлчилгээний нөхцөл, үнийг жил бүр, тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдол бүрд хянана” гэж заасан.

ЭХЗХ нь Эрчим хүчний тухай хуулийн 11.2-т заасны дагуу аймгийн ЭХЗХ-ийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилсон бөгөөд зохицуулах зөвлөлийн 2019, 2020 оны 01 дугаар тогтоолоор үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, тус төлөвлөгөөнд хяналтын чиглэлээр дараах ажлуудыг хийхээр тусгасан байна.

Тухайлбал: 2019 онд МХГ-тай хамтран аймгийн төвийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд техник технологийн бүрэн бүтэн байдалд хяналт шалгалт хийх, 2020 онд сумдад баригдаж байгаа халаалтын зуух, инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажилд хяналт тавихаар төлөвлөж баталсан байна.

Хяналт шалгалтын төлөвлөгөөт ажлын хүрээнд 2019 онд аймгийн МХГ-тай хамтран Чандмань бадрал ОНӨХХК, Чандмань Илч ОНӨХХК, БАҮ-ний III ангийн төвлөрсөн халаалтын зууханд хяналт шалгалт хийж, шалгалтаар 33 зөрчил илрүүлж, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг сайжруулж, зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж хүргүүлсэн байна.

Харин 2020 онд Чандмань бадрал, Чандмань Илч ОНӨХХК-ний техник, тоног төхөөрөмжийн их болон урсгал засвар, шинэчлэл, насжилт, өвөлжилтийн бэлтгэл ажлын байдал, эрчим хүчний технологийн горимын мөрдөлт, хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан эрчим хүчээр хангаж байгаа байдал, аваар ослоос сэргийлэх зохион байгуулалтын хэрэгжилт, түлш хангамжийн нөөцлөлт, сэлбэг материалын нөөц, баримт бичгийн бүрдүүлэлт зэрэг асуудлуудыг хамруулан шалгаж, шалгалтаар илрүүлсэн зөрчлийг арилгуулахаар аймгийн МХГ-ын улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж, биелэлтийг тооцож ажилласан байна.

ЭХЗХ-ны бүрэлдэхүүнд орон тооны 2, орон тооны бус 2, нийт 4 зохицуулагч ажиллахаар тусгаж, зохицуулагчид нь эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн эрхтэй байхаар заасан бөгөөд Эрчим хүчний тухай хуулийн 34.1.1-т мэргэжлийн хяналт тавих улсын байцаагч нь эрчим хүчний тухай хууль тогтоомжийн биелэлт, эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралт, засвар, ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлагыг хэрэгжүүлэхэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Дээрх чиг үүргийн хүрээнд ЭХЗХ нь 2019, 2020 онуудад тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хянах чиглэлээр хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөг баталсан байх ба 2019, 2020 онуудад Чандмань Илч ОНӨХХК-ний тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилт, зорилтын биелэлтэд хяналт шалгалт хийхээр, 2020 онд аймгийн ЭХЗХ-өөс олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд туслан зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр тусгаж ЭХЗХ-ний цахим хуудаст хяналт шалгалт хийгдсэн гэж мэдээлсэн боловч ЭХЗХ-оос аймгийн ЭХЗХ-д хяналт шалгалтын тайлан ирүүлээгүй, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдэд зөвлөмж, чиглэл хүргүүлээгүй, хяналт үр дүнтэй хийгдсэн нь тодорхойгүй байна.

А.2. Төсөвт байгууллагуудын түлш халаалтын зардлыг тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөх шаардлагатай байна.

А.2.1. Төсөвт байгууллагууд түлш, халаалтын зардлыг үндэслэлтэй тооцож төлөвлөөгүй байна.

Орон нутгийн төсөвт байгууллага болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ТЗШ-ийн гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсөвт байгууллага, сумдын Засаг дарга нар нь СС-ын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-д заасан хугацаанд аймгийн Засаг даргад төсвийн төсөөллийг хүргүүлсэн байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын түлш халаалтын зардлын төсвийн төлөвлөлтийг авч үзэхэд 2019 онд 5,851.6 сая төгрөг, 2020 онд 6,302.5 сая төгрөгөөр тус тус төлөвлөжээ. МУ-ын Төсвийн тухай хуулийн 6.1-т "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"-аар тусгасан байхад төсвийн захирагчид төсвийн төсөөллийг боловсруулахдаа дараах зөрчлүүдийг гаргасан байна. Үүнд:

➤ Төсөвт байгууллагууд нь төсвийн төсөөлөлд түлш халаалтын зардлыг төлөвлөхдөө барилга байгууламж шинээр баригдаагүй, талбайн хэмжээ нэмэгдээгүй байхад бодит хэмжээг өсгөж төлөвлөсөн. /Хавсралт №1-т харуулав/

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2019, 2020 оны төсвийн төсөл, гүйцэтгэлээрх халаалтын талбайн харьцуулалт

Хүснэгт №3

/сая төгрөг/

Д/д	Он	Төсвийн төсөөлөлд тусгасан		Нэхэмжлэхэд тусгасан талбайгаар тооцсон		Илүү төлөвлөсөн		Дутуу төлөвлөсөн
		м³	Мөнгөн дүн	м³	Мөнгөн дүн	м³	Мөнгөн дүн	м³
1	2019	63,304	662.4	54,660	552.0	-8,644	-110.4	7,754
2	2020	166,089	2,108.6	132,885	1,366.2	-33,204	-742.3	6,292

Төсвийн төсөөлөл боловсруулахдаа 2019 онд 17 байгууллага халаалтын талбайн хэмжээг нийт 8,644 м³-ээр илүү тооцоолж 110.4 сая төгрөг, 2020 онд 33,204 м³-ээр илүү тооцоолж 742.3 сая төгрөгийг тус тус илүү тооцоолж төлөвлөсөн нь 2020 оны нийт анхан шатны баримтад тусгасан талбайн хэмжээний 25 хувийг эзэлж байна.

Харин 2019 онд 10 байгууллага 7,754м³, 2020 онд 11 байгууллага 6,292 м³ талбайг тус тус дутуу төлөвлөсөн байна.

➤ Төсвийн төсөөлөл болон зардлын бодит зарцуулалтаар халаалтын талбайн хэмжээг авч үзэхэд ижил байх боловч нягтлан бодогчид тогтоосон тарифт үнийг баримтлалгүй тооцоолол хийж төлөвлөснөөс аудитад хамрагдсан онуудад нийт 410.5 сая төгрөгийн түлш халаалтын зардлыг төсвийн төсөөлөлд илүү тусгасан байна.

Төсвийн төсөөлөл болон зардлын бодит зарцуулалтаар халаалтын талбайн хэмжээ

Хүснэгт №4 /сая төгрөг/

Д/д	Он	Талбайн хэмжээ	Төсвийн төсөлд тусгагдсан саналын дүн	Гүйцэтгэлээр төлбөл зохих дүн	Илүү төлөвлөсөн дүн
1	2019	129,165	1,632.1	1,335.2	296.9
2	2020	100,856	1,083.2	969.6	113.6

➤ Төсөвт байгууллагын нягтлан бодогчид төсвийн төсөөллийг бэлтгэхдээ өмнөх онуудын түлш халаалтын зардлын гүйцэтгэлд дүн шинжилгээ, харьцуулалт хийхгүйгээр төлөвлөдөг байна. /Хавсралт№2-т харуулав/

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын түлш халаалтын зардлын 2019, 2020 оны төсвийн төсөл, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийн харьцуулалт

Хүснэгт №5 /сая төгрөг/

Д/д	Он	Өмнөх онуудын зардлын гүйцэтгэл	Төсвийн төсөлд тусгасан дүн	Илүү төлөвлөсөн дүн
1	2019	4,175.2	5,621.9	1,535.0
2	2020	4,594.6	5,184.7	621.4

Орон нутгийн төсөвт болон ТЗШ-ийн байгууллагуудын санхүүгийн ажилтнууд түлш халаалтын зардлын төсвийн төсөөллийг боловсруулахдаа 2019 онд 84 байгууллага өмнөх оны гүйцэтгэлээс 1,535.0 сая төгрөгөөр, 2020 онд 621.3 сая төгрөгөөр тус тус илүү тооцоолж төлөвлөсөн байна.

Байгууллагуудын төсвийн төсөлд төлөвлөсөн түлш халаалтын зардлын дүнг зардлын бодит гүйцэтгэлтэй харьцуулахад төсвийн төсөөлөл боловсруулахдаа 2019 онд 75 байгууллага халаалтын зардлыг бодит гүйцэтгэлээс 1,082.4 сая төгрөгөөр, 2020 онд 74 байгууллага 1,064.4 сая төгрөгөөр илүү, 21 байгууллага 56.6 сая төгрөг, 28 байгууллага 444.5 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн байх ба зардлын илүү төлөвлөсөн дүн нь 2019 оны бодит зарцуулалтын 24.1 хувь, 2020 оны 18.7 хувийг тус тус эзэлж байна. /Хавсралт№3-т харуулав/

Түлш халаалтын зардлын төлөвлөсөн дүнг бодитоор гарахаар тооцоолсон зардалтай хийсэн харьцуулалт

Хүснэгт №6 /сая төгрөг/

Д/д	Он	Төсвийн төсөлд тусгасан дүн	Зардлын бодит гүйцэтгэл	Илүү төлөвлөсөн дүн	Дутуу төлөвлөсөн дүн
1	2019	5,524.6	4,485.3	1,082.3	56.6
2	2020	6,297.2	5,677.3	1,064.4	444.5

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын төсвийн захирагч, санхүүгийн ажилтнууд түлш халаалтын зардлыг тооцож төлөвлөхдөө барилга байгууламжийн талбайн хэмжээг үндэслэлгүй нэмэгдүүлэх, тогтоосон үнэ тарифыг өөрчлөгдөөгүй байхад тус үнийг баримтлахгүйгээр тооцоолох, зардлын өмнөх онуудын гүйцэтгэлийг харьцуулж дүн шинжилгээ хийгээгүйгээс үндэслэлтэй төлөвлөөгүй зөрчилд ТЗШ болон санхүүгийн ажилтнуудад түлш халаалтын зардлын төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах талаар зөвлөмж хүргүүлээ:

А.2.2. Төсвийн төсөөлөлд тусгагдсан түлш, халаалтын зардалд дүн шинжилгээ, тооцоолол хийж бодит хэрэгцээг тодорхойлон, нэгтгэн боловсруулахад аймгийн СТХС чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

МУ-ын Төсвийн тухай хуулийн 14.2.2 "ТЕЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 27.1 "Төсвийн төслийг боловсруулахад төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх", 31.4.5 "ТЕЗ-ийн төсвийн төсөлд төсвийн гүйцэтгэлийн дүн шинжилгээ, тухайн жилийн төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн урьдчилсан тооцоог хавсаргана", 27.1.2-т "Төсвийн төслийг боловсруулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх шаардлага тавигдана" гэж заасан.

Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", аймгийн 2019, 2020 онуудын төсвийн хүрээний мэдэгдэл болон холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн түлш халаалтын зардлыг 2019 онд 6,157.7 сая төгрөгийн, 2020 онд 6,476.8 сая төгрөгөөр төлөвлөн төсвийн төсөөлөлд тусгаж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Төлөвлөлт, батлагдсан зардлын харьцуулалт

Хүснэгт №7							/сая төгрөг/
Д/д	Он	Байгууллагуудын төсвийн төсөлд тусгасан	Сангийн яаманд хүргүүлсэн	СЯ-ны хянасан	Аймаг, сумдын ИТХ-ын эхний баталсан 2018.12.	Аймаг, сумдын ИТХ-ын тодотгож баталсан 2019.12	
1	2019	5,873.1	6,157.7	5,074.1	5,252.8	4,997.8	
2	2020	6,324.4	6,476.8	5,918.2	6,173.9	5,643.8	

ТЕЗ-ийн харьяа болон ТЗШ-ийн байгууллагууд төсвийн төсөөлөлд түлш халаалтын зардлыг 2019 онд 5,873.1 сая төгрөгөөр, ТЕЗ-ийн төсвийн төсөөлөлд 6,157.7 сая төгрөгөөр тусган хүргүүлж, Сангийн яамнаас 5,074.1 сая төгрөгөөр хянасныг аймаг, сумдын ИТХ-аас 5,252.8 сая төгрөг, тодотгож 4,997.8 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Харин 2020 онд байгууллагууд төсвийн төсөөлөлдөө түлш халаалтын зардлыг 6,324.4 сая төгрөгөөр тусгасныг ТЕЗ-ийн төсвийн төсөөлөлд 6,476.8 сая төгрөгөөр тусган хүргүүлж, Сангийн яамнаас 5,918.2 сая төгрөгөөр хянасныг аймаг, сумдын ИТХ 6,173.9 сая төгрөг анх баталж, 5,643.8 сая төгрөг болгон тодотгол хийсэн байна.

Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн СТС-ын ажилтны ажил үүргийн жишиг заавар"-ын 1.1.3-т "СТСХ-ийн дарга нь ТЕЗ-ийн төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах ажлыг зохион байгуулах", 1.2.1-т "ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогч нь ТЕЗ-ийн төсвийн төсөл боловсруулахад санал өгөх", 1.4.2-т "Төсвийн мэргэжилтэн нь ТЕЗ-ийн харьяа төсвийн байгууллагаас ирүүлсэн төсвийн төслийг холбогдох эдийн засгийн тооцоо, судалгаан дээр үндэслэн нэгтгэн боловсруулах", 1.4.3-т "Сумдын ирүүлсэн төсвийн төслийг холбогдох ЭЗ-ийн тооцоо, судалгаан дээр үндэслэн нэгтгэн боловсруулах", 1.4.5-д "ТЕЗ-ийн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулах" гэсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Гэтэл аймгийн СТСХ-ийн төсвийн мэргэжилтэн байгууллагуудаас ирүүлсэн төсвийн төслийн саналд харьцуулалт судалгаа хийхгүйгээр түлш халаалтын зардлыг ТЕЗ-ийн төсвийн төсөлд тусган аймгийн ИТХ-аар батлуулснаас жилийн эцэст тус зардлын төсвийг дахин тодотгож баталсан байна.

График №2



Аудитад хамрагдсан хугацаанд түлш халаалтын зардлыг аймаг, сумдын ИТХ-аар 2019 онд 5,257.0 сая төгрөгөөр баталж, тодотголоор 13 байгууллагын төсвийг 72.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 20 байгууллагын төсвийг 331.3 сая төгрөгөөр бууруулан, зардлын нийт дүнг 4,997.8 сая төгрөгөөр баталсан байна.

Харин 2020 онд 6,153.6 сая төгрөгөөр баталж, тодотголоор 28 байгууллагын төсвийг 303.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 27 байгууллагын төсвийг 206.7 сая төгрөгөөр бууруулж, 6,250.6 сая төгрөгөөр баталсан байна.

ТЕЗ-ийн харьяа зарим байгууллагын төсвийн захирагч, санхүүгийн ажилтнуудын үндэслэлтэй төлөвлөөгүй төслийн төсөлд СТСХ-ийн холбогдох албан тушаалтнууд тооцоо, судалгаа хийхгүй нэгтгэж байгаагаас дараах зөрчил гарсан байна.

➤ Төсөвт байгууллагуудын төсвийн төсөлд тусгаж ирүүлсэн түлш халаалтын зардлын дүнг тооцоо судалгаагүйгээр бууруулж батлуулснаас 2019 онд төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 21 байгууллагын зардалд 35.8 сая төгрөгийн, 2020 онд 11 байгууллагын зардалд 62.5 сая төгрөгийн зардлын хэтрэлт үүсэж бусад тогтмол зардлаас шилжүүлэн зарцуулсан байна. /Хавсралт №4-т харуулав/

➤ Нөгөө талаас түлш халаалтын зардлыг бодитоор үндэслэлтэй тооцож төлөвлөөгүй төслийн төсөлд тусгасан дүнгээр батлуулснаас 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 16 байгууллагын зардалд 142.5 сая төгрөгийн, 2020 онд 16 байгууллагын зардалд 181.2 сая төгрөгийн зардлын хэмнэлт үүссэн байна. /Хавсралт №5-д харуулав/

ТЕЗ-ийн төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, эдийн засгийн тооцоо, судалгаан дээр үндэслэн нэгтгэн боловсруулах ажлыг чанаржуулах, холбогдох мэргэжилтнүүдийг хариуцлагажуулж, зардлын төсвийг үр ашигтай төлөвлөж, батлуулах талаар зөвлөмж хүргүүлээ.

Б. ТҮЛШ ХАЛААЛТЫН ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙГАА Ч ТОДОРХОЙ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛСНААР ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ БОЛОМЖ БАЙНА.

Б.1. Түлш халаалтын зардлын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, тайлан, мэдээнд гүйцэтгэлийг үнэн зөв тусгах шаардлагатай байна.

Б.1.1. ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 50 орчим хувь нь төсвийн гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан байна.


Түлш халаалтын зардлын гүйцэтгэлийг шалгагдагч байгууллагын нэхэмжлэх, худалдан авсан түлээ, нүүрс, өмнөх болон тайлант оны түлш халаалтын зардлын өглөг, авлагын үлдэгдэл, цахилгаанаар халаасан саруудын гэрэл цахилгааны нэхэмжлэх зэрэг санхүүгийн анхан шатны баримт материалд үндэслэн тооцоход түлш халаалтын зардалд 2019 онд 103 байгууллагад 4,821.1 сая төгрөгийн, 2020 онд 105 байгууллагад 5,520.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагуудын гүйцэтгэлээр зарцуулсан түлш халаалтын зардал нь 2019 онд нийт гүйцэтгэлийн 74.9 хувь, 2020 онд 73.2 хувь, харин орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын зардал нь 2019 онд 25.1 хувь, 2020 онд 26.8 хувийг тус тус эзэлж байна.

Түлш, халаалтын зардлын гүйцэтгэл /байгууллагын төрлөөр/

Хүснэгт №8		/сая төгрөг/					
Байгууллагын нэр, төрөл		2019			2020		
		Байгууллагын тоо	Бодит гүйцэтгэл	Хувь	Байгууллагын тоо	Бодит гүйцэтгэл	Хувь
Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллага	ЗДТГ, ЗАА	16	495.2	10.3%	16	557.6	10.1%
	Соёлын байгууллага	18	697.6	14.5%	18	896.7	16.2%
	Бусад	4	17.5	0.4%	4	22.7	0.4%
	Нийт	38	1,210.3	25.1%	39	1,477.0	26.8%
Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллага	Сургууль	20	2,546.7	52.8%	20	2,819.2	51.1%
	Цэцэрлэг	30	841.6	17.5%	31	941.2	17.0%
	ЭМТ	13	193.5	4.0%	13	254.1	4.6%
	Бусад	2	29.0	0.6%	2	29.1	0.5%
	Нийт	65	3,610.8	74.9%	66	4,043.6	73.2%
БҮГД		103	4,821.1	100%	104	5,520.6	100%

Дээрх байгууллагуудыг дулаанаар хангахад 2019 онд нийт 4,024 тонн, 2020 онд 3,298 тонн нүүрс худалдан авсан бол төвлөрсөн дулаанд холбогдсон байгууллагууд 2019 онд 2,918,895 м.куб, 2020 онд 3,418,238 м.куб. хэмжээгээр эзлэхүүнийг тооцон халаалтын зардалд тусгасан байна. *График №3*



Төсвийн тухай хуулийн 16.5.7-д “Төсвийн шууд захирагч нь байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг... үнэн зөв гаргах...”, 41.2.3-т “Бүх шатны төсөв захирагч нь дараах үүрэг хүлээнэ... төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэж тусгасан байна.

Аудитаар шалгагдагч байгууллагын анхан шатны баримтад үндэслэн тооцоход 2019 онд нийт 4,821.1 сая төгрөгийн түлш халаалтын зардал бодитоор гарсан байхад төсвийн гүйцэтгэлийн тайланд 4,846.3 сая төгрөгөөр, 2020 онд 5,520.6 сая төгрөгийн түлш халаалтын зардал гарсан байхад 5,633.0 сая төгрөгөөр тус тус тайлагнасан байна. Үүнд, 2019, 2020 онд давхардсан тоогоор нийт 65 байгууллага бодитоор гарсан түлш халаалтын зардлыг 227.3 сая төгрөгөөр илүү тусгаж, 42 байгууллага 89.7 сая төгрөгөөр дутуу тусгаж, нийт 317.0 сая төгрөгөөр төсвийн гүйцэтгэлийн тайланд түлш халаалтын зардлыг зөрүүтэй илэрхийлсэн байна. Гүйцэтгэлийг зөрүүтэй илэрхийлсэн тус алдаа нь 2019 оны төсвийн гүйцэтгэлийн дүнгийн 1.4 хувь, 2020 онд 4.5 хувьтай тэнцэж байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд зөрүүтэй илэрхийлсэн түлш, халаалтын зардлын гүйцэтгэл

Хүснэгт №9

/сая төгрөг/

Он	Төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан гүйцэтгэл	Бодитоор гарсан гүйцэтгэл	Зөрүү	Илүү дүнгээр тайлагнасан		Дутуу дүнгээр тайлагнасан	
				байгууллагын тоо	үнийн дүн	байгууллагын тоо	үнийн дүн
2019	4,846.3	4,821.1	25.2	32	47.4	21	22.2
2020	5,633.0	5,520.6	112.4	33	179.9	21	67.5
нийт	10,479.3	10,343.2	136.1		227.3		89.7

Түлш халаалтын зардлаас цэвэр бохир ус, гэрэл цахилгааны төлбөрийг төлсөн боловч төсвийн гүйцэтгэлийн тайланд тухайн зардлын гүйцэтгэлд тусгахгүйгээр түлш халаалтын зардлыг өсгөж тайлагнасан, гэрэл цахилгаан болон цэвэр бохир усны зардлаас төлсөн түлш халаалтын төлбөрийг түлш халаалтын зардал бүртгэж тайлагнаагүй байна.

Түлш халаалтын төлбөр болон бусад зардал хооронд гүйлгэн зарцуулсан зардал

Хүснэгт №10

/сая төгрөг/

Он	Түлш халаалтын зардлаас шилжүүлсэн					Түлш халаалтын төлбөрт шилжүүлсэн			
	Гэрэл цахилгааны төлбөрт	Цэвэр бохир усны төлбөрт	Зориулалт бус зардалд	Актын төлбөрт	Нийт	Гэрэл цахилгааны зардлын төсвөөс	Цэвэр бохир усны зардлын төсвөөс	Тээвэр шатахууны зардлын төсвөөс	Нийт
2019	13.7	16.5	14.5	5.3	50.0	4.2	19.2	0.5	23.9
2020	6.2	7.6	72.8		86.6	12.5	85.8		98.3
нийт	19.9	24.1	87.3	5.3	136.6	16.7	105.0	0.5	122.2

Дээрх хүснэгтээс түлш халаалтын зардлаас бусад зардалд шилжүүлэн зарцуулсан байдлыг авч үзэхэд гэрэл цахилгаан болон цэвэр, бохир усны зардалд 2019 онд 30.2 сая төгрөг буюу 60 хувь, 2020 онд 13.8 сая төгрөг буюу 16 хувийг, зориулалт бус зардалд /дулааны шугамын засвар, үйлчилгээ, түлээ нүүрсний дэмжлэг гэх мэт/ 2019 онд 14.5 сая төгрөг буюу 29 хувь, 2020 онд 72.8 сая төгрөг буюу 84 хувийг зарцуулсан байна.

Үүнээс үзэхэд, 2020 онд түлш халаалтын зардлаас цэвэр, бохир ус болон гэрэл цахилгааны зардалд шилжүүлэн зарцуулсан дүн буурсан боловч, зориулалт бус зардалд зардалд зарцуулсан дүн нэмэгдсэн байна.

Үүнээс гадна, гэрэл цахилгаан болон цэвэр, бохир усны зардлаас түлш халаалтын зардалд 2019 онд нийт 23.4 сая төгрөг, 2020 онд нийт 98.3 сая төгрөгийг шилжүүлсэн нь түлш халаалтын зардлын төсөв хүрэлцээгүй, батлагдсан төсөв хүрэлцээтэй хэдий ч санхүүжилтийг байгууллагад дутуу олгосноос шалтгаалсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг буруу илэрхийлснээс төсвийн хэтрэлт болон хэмнэлтийг бодитоор тайлагнаагүй байна. 2019 онд 209.5 сая төгрөгийн хэмнэлттэй байтал төсвийн гүйцэтгэлийн тайланд гүйцэтгэлийг 36.9 сая төгрөгөөр бага буюу 172.6 сая төгрөгөөр тусгасан, 2020 онд 898.7 сая төгрөгийн хэмнэлттэй байтал 745.1 сая төгрөгийн хэмнэлтийг тусгасан байна. Мөн 2019 онд 38.8 сая төгрөгөөр түлш халаалтын зардлын төсвийг хэтрүүлэн зарцуулсан байтал 11.7 сая төгрөгөөр бага буюу 27.1 сая төгрөгөөр, 2020 онд 50.0 сая төгрөгөөр төсвийг хэтрүүлэн зарцуулсан ба үүнийг 41.2 сая төгрөгөөр бага буюу 8.8 сая төгрөгөөр хэтэрсэн гэж тусгасан байна.

**Түлш халаалтын зардлын төсвийн
хэтрэлт, хэмнэлтийн зөрүү**

Хүснэгт №11

/сая төгрөг/

Он	Төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан					Бодитоор гарсан			Гүйцэтгэлийг буруу илэрхийлснээс үүссэн алдаа		
	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хэтрэлт	Хэмнэлт	Гүйцэтгэл	Зөрүү	Хэтрэлт	Хэмнэлт	Хэтрэлт	Хэмнэлт
А	1	2	3=1-2	4	5	6	7=1-6	8	9	10=4-8	11=5-9
2019	4,991.8	4,846.3	145.5	27.1	172.6	4,821.1	170.7	38.8	209.5	(11.7)	(36.9)
2020	6,369.3	5,633.0	736.3	8.8	745.1	5,520.6	848.7	50.0	898.7	(41.2)	(153.6)

Төсвөөс түлш халаалтын төлбөрийг шилжүүлэхдээ төлбөрийн хүсэлтэд зардлын эдийн засгийн ангиллыг цэвэр бохир ус, гэрэл цахилгаан зэргээр буруу тусгах, мөн гэрэл цахилгаан болон цэвэр бохир усны төлбөрийг шилжүүлэхдээ “Түлш халаалт” гэсэн зардлын эдийн засгийн ангиллыг тусгаж, улмаар уг алдаа нь төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь зардлын гүйцэтгэлийг зөрүүтэй илэрхийлж, төсвийн тайлан, мэдээг зөрүүтэй тайлагнах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Энэ нь төсвийн шууд захирагч, байгууллагын нягтлан бодогч болон аймаг, сумдын төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэх, дотоод хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтны хариуцлагагүй үйлдэлтэй холбоотой байна.

Зардлын төсвийн гүйцэтгэлийг буруу илэрхийлснээр Засгийн газар, аймгийн ИТХ, ТЭЗ, олон нийт гэх мэт санхүүгийн тайлан хэрэглэгчдийг бодитой бус мэдээллээр хангах, төсөв болон зардлын гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн тоон мэдээлэлд үндэслэн хийгдэх шинжилгээний дүн, дүгнэлт буруу байх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгохоор байна.

Улаанбадрах сумын төсөвт байгууллагууд дулааны эрчим хүчээр хангагдах гэрээг СИЗУ ХХК-тай 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр байгуулж, мөн өдрөөс эхлэн дулаанаар хангагдахаар гэрээнд тусгасан байна. Гэтэл дулааны төлбөрийг 2020 оны 10 дугаар сараас буюу дулаанаар хангаж эхлэх туршилтын хугацаанаас тооцож төлбөрийг шилжүүлэн, зардлын гүйцэтгэлээр тусгасан байна.

Дээрх зөрчил нь Эрчим хүчний тухай хуулийн 29.1.4-т “Эрчим хүчээр хангагчийн эрх, үүрэг гэрээнд заасан хугацаанаас эхлэн эрчим хүчээр хангах” гэж заасныг зөрчсөн байна.

Түлш, халаалтын зардлын төсвийн хэтрэлт болон хэмнэлт:

Аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан түлш халаалтын зардлын төсөв болон гүйцэтгэлийн тоон мэдээнд үндэслэн бодит зардлыг тооцоход аудитад хамрагдсан онуудад түлш халаалтын зардал нь нийт дүнгээр хэмнэгдсэн байна. Доорх хүснэгтэд тооцоолсон түлш халаалтын зардлын гүйцэтгэлд оны эхний болон эцсийн өглөг, авлагын дүнг тохируулаагүй ба зөвхөн дулаанаар хангагч байгууллагуудын нэхэмжлэхэд үндэслэн тооцов.

2019 оны төсвийн хэмнэлтийн 30.1 хувь буюу 50.0 сая төгрөг орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллага, 69.9 хувь буюу 111.6 сая төгрөг тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагын төсвийн хэмнэлтээс бий болсон байна.

2020 онд үүссэн хэмнэлтийн 28.1 хувь буюу 193.9 сая төгрөгийг орон нутгийн, 71.9 хувь буюу 491.7 сая төгрөгийг нь тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагын хэмнэлтээс бий болсон байна.

**Түлш, халаалтын зардлын төсөв, гүйцэтгэл
/байгууллагын төрлөөр/**

Хүснэгт №12 /сая төгрөг/

Он	Байгууллагын төрөл	Батлагдсан төсөв	Бодит гүйцэтгэл	Зөрүү	Хэтрэлт		Хэмнэлт	
					байг-н тоо	дүн	байг-н тоо	дүн
2019	Орон нутгийн	1,260.9	1,210.9	50.0	12	9.9	22	59.9
	Тусгай зориулалтын шилжүүлгийн	3,730.9	3,619.3	111.6	20	39.3	31	150.9
	нийт	4,991.8	4,830.2	161.6	32	49.2	53	210.8
2020	Орон нутгийн	1,834.1	1,640.2	193.9	2	19.9	36	213.9
	Тусгай зориулалтын шилжүүлгийн	4,535.2	4,037.5	497.7	16	49.3	47	547.0
	нийт	6,369.3	5,677.7	691.6	18	69.2	83	760.9

Хэдийгээр түлш халаалтын зардал нийт дүнгээрээ хэмнэгдсэн ч 2019 онд 49.2 сая төгрөгөөр нийт 32 байгууллага, 2020 онд 69.2 сая төгрөгөөр нийт 18 байгууллага батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Аудитад хамрагдсан 2019, 2020 онуудад зардлыг хэтрүүлэн зарцуулсан нь төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй, жилийн дундуур зарим төсөвлөгдөөгүй объектын халаалтын зардлыг төлсөн зэрэг шалтгаантай байна. Тухайлбал,

- ✓ 2019 онд Сайншанд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн халаалтын зардал сар бүр тогтмол 42.2 сая төгрөг төлсөн ба 295.4 сая төгрөгийн зардал гарсан байтал 292.9 сая төгрөгөөр төсөвлөсөн,
- ✓ Сайншанд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль мөн адил сар бүр тогтмол 28.07 сая төгрөгийг халаалтын зардал төлж, 196.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байтал 193.0 сая төгрөгөөр төсвийг баталсан байна.

- ✓ Сайншанд сумын 7 дугаар цэцэрлэг /Зүүнбаян багт байрлах/-ийн түлш халаалтад сар бүр тогтмол 3.54 сая төгрөг, жилдээ нийт 24.8 сая төгрөг төлөхөөр байтал төсвийг 16.7 сая төгрөгөөр буюу 8.1 сая төгрөгөөр дутуу баталсан байна.

2019 онд төсөвт тусгагдаагүй зарим объектын халаалтын зардлыг төлсөн байх ба цаашид төсөвт тусгах асуудлыг судлан шийдвэрлэх нь зүйтэй байна. Тухайлбал,

- ✓ Замын-Үүд сумын 3 дугаар сургууль нь Энх тайвны корпусын сайн дурын ажилтны амьдардаг орон сууцны төлбөр болох 117.7 мянган төгрөгийг 2018 онд байгуулсан санамж бичигт заасны дагуу төлсөн.
- ✓ Өргөн сумын ЗДТГ-т бүртгэлтэй албан хаагчдын байрны төлбөрт 301.2 мянган төгрөг, цагдаагийн байрны дулааны төлбөрт 2,207.6 мянган төгрөгийг төлсөн байна.

Аудитад хамрагдсан онуудад үүссэн хэмнэлтэд шинжилгээ хийхэд төсвийг үндэслэлгүй тооцох, халаалтын улиралд дулаанаар хангагдаагүй өдрүүдийн халаалтын зардлыг тооцож, түлш халаалтын төлбөрөөс хасаж шилжүүлэх, үнэ төлбөргүйгээр нүүрс авах, төсвийн орлогын төлөвлөгөө тасарсан зэрэг шалтгаантай байна. Тухайлбал, халаалтаар хангагдаагүй өдрүүдийн төлбөр болон үнэгүй авсан нүүрсний төлбөрөөс 2019 онд нийт 11.8 сая төгрөг, 2020 онд 47.0 сая төгрөг тус тус бодитоор хэмнэсэн байна.

Мөн 2020 онд орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарснаас орон нутгийн төсөвт байгууллагад олгох санхүүжилтийг 628.2 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагад олгох тогтмол зардлыг санхүүжилтийг 632.7 сая төгрөгөөр дутуу олгосон байна. Үүнтэй холбоотойгоор зарим байгууллагад түлш халаалтын зардлын хэмнэлт үүссэн мэт тайланд илэрхийлэгдсэн байгаа боловч, түлш халаалтын өр төлбөртэй гарсан байна.

Төсвийг үндэслэлгүйгээр тооцсоноос шалтгаалж, түлш халаалтын төлбөрийг бусад тогтмол зардлаас шилжүүлсэн, мөн түлш халаалтын өр төлбөр үүссэн байна.

Б.1.2. Өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулан, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах шаардлагатай байна.

Түлш халаалтын төлбөртэй холбоотойгоор 2019, 2020 онд нийт 17 байгууллагад өр төлбөр болон авлага үүссэн ба он дамжсан 65.7 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэгдсэн байна.

Түлш халаалтын өр төлбөр, авлагын үлдэгдэл

Хүснэгт №13		/сая төгрөг/							
Үзүүлэлт	2019						2020		
	2019.01.01			2019.12.31			2020.12.31		
	Байгууллагын тоо	Харилцагчийн тоо	Эхний үлдэгдэл	Байгууллагын тоо	Харилцагчийн тоо	Эцсийн үлдэгдэл	Байгууллагын тоо	Харилцагчийн тоо	Эцсийн үлдэгдэл
Өр төлбөр	4	5	12.3	5	6	15.3	9	10	170.5
Авлага				2	2	1.3	2	2	2.3

Төсвийн тухай хуулийн 16.5.7-д *“Төсвийн шууд захирагч нь байгууллагын санхүүгийн ... тайланг... үнэн зөв гаргах...”*, Нягтлан бодох бүртгэлийн 20.2.3-т *“Ерөнхий нягтлан бодогч нь дараах үүрэг хүлээнэ....холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”* гэж заасан.

Дээрх заалтыг мөрдөхгүйгээр 2019 оны эхний үлдэгдэлд 3.3 сая төгрөгийн өр төлбөр, 2019 оны эцсийн үлдэгдэлд 0.8 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна. 2020 оны эцсийн үлдэгдэлд 3.6 сая төгрөгийн өр төлбөр, 1.8 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна. Тухайлбал,

- ✓ Өргөн сумын ЗДТГ нь Цагдаагийн байрны дулааны өр төлбөр болон 3.3 сая төгрөгийг 2018 оны санхүүгийн тайланд тусгаагүй байна. Тус байгууллагын нягтлан бодогч нь уг төлбөрийн нэхэмжлэхийг 2019 онд хүлээн авсан ба Цагдаагийн байрны дулааны төлбөрийг төлөх талаар мэдээгүй гэсэн тайлбарыг өгсөн.
- ✓ Хатанбулаг сумын ЭМТ-ын 2019 оны санхүүгийн тайланд 0.8 сая төгрөгийн авлага тусгагдаагүй байна. Таван толгой ХХК-с 40 тонн нүүрсний үнийг шилжүүлж, 2019 онд 20 тонн-ийг тээвэрлэн авчирсан ба үлдэх 20 тонн нүүрсийг тээвэрлэлтийн шалтгаанаар авч чадаагүй байна. Гэвч бүртгэлд нийт 40 тонн нүүрсний үнийг шилжүүлэхдээ шууд зардалд бүртгэж, авлага үүсгээгүй байна.
- ✓ Улаанбадрах сумын ЕБС-ийн 2020 оны санхүүгийн тайланд СИЗУ ХХК-аас авах авлага болох 1.8 сая төгрөгийн авлагыг тусгаагүй байна. Улаанбадрах сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайланд 3.6 сая төгрөгийг СИЗУ ХХК-д төлөх өр төлбөр тусгагдаагүй ба тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2 дугаар зүйлд ерөнхий нягтлан бодогчийн үүргийг тусгасан байх ба 20.2.5-д *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, 20.2.6-д *“...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* гэж тусгасан байна.

Тайлант 2019 болон 2020 онд түлш авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байгаа хэдий ч зарим байгууллага тооцооны нийлээгүй, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Тухайлбал, Дэлгэрэх сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд 1,067.6 мянган төгрөгийг, 2020 оны санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдэлд 705.7 мянган төгрөгийг нүүрс бэлтгэн нийлүүлэгч иргэнд төлөхөөр тусгасан ч тооцоо нийлээгүй.

Дэлгэрэх сумын ЭМТ-ийн 2019 санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд 843.0 мянган төгрөгийг татварын байгууллага болон нүүрс бэлтгэн нийлүүлэгч иргэнд өгөхөөр тусгасан ч, үлдэгдлийг баталгаажуулаагүй. Хатанбулаг сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдэлд Таван толгой ХХК-с авах 20 тонн нүүрсний үнэ болох 770.0 мянган төгрөгийн тооцоог нийлээгүй байна.

Өргөн сумын соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдэлд Чандмань-Илч ХХК-д 2,098.5 мянган төгрөгийг төлөхөөр тусгаж, үүнд тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдсэн гэх боловч аудитын явцад ирүүлээгүй.

Түлш халаалтын өр төлбөр болон авлагын тооцоог тухай бүр нийлэхгүй, үлдэгдлийн баталгаа, тооцоо нийлсэн актыг үйлдэхгүй байгаа нь байгууллагын нягтлан бодогчийн хариуцлагагүй үйлдэлтэй холбоотой байна. Мөн үүнээс гадна, тооцооны үлдэгдлийн баталгааг архивлаагүй, нягтлан бодогчид солигдсон зэргээс шалтгаалж тооцооны үлдэгдлийн баталгааг олохгүй байх, тухайн бүр үйлдээгүй мэтээр тайлбар өгөх байдал аудитын явцад ажиглагдсан.

Авлагыг санхүүгийн тайланд үнэн зөв тусгахгүй байх, үлдэгдлийг баталгаажуулахгүй, акт үйлдэхгүй байснаар харилцагч байгууллагад илүү төлбөр шилжүүлэх, төсвийг үр ашиггүй зарцуулах зардлыг бодитоор төлөвлөхөд эрсдэлтэй ба өр төлбөрийг тусгахгүй орхигдуулах, үлдэгдлийг баталгаажуулахгүй байх нь дараа жилүүдэд төсөв хүрэлцэхгүй байх сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Дээрх өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлагыг холбогдох төсөвт байгууллагуудад хүргүүлэв.

Б.1.3. Түлш халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл болон дулаанаар хангах үйл ажиллагаанд чиглэсэн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

МУ-ын Төсвийн тухай хуулийн 14.2.10-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 16.5.6-д “Төсвийн шууд захирагч дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасан.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь хуульд заасан чиг үүргийн хүрээнд орон нутгийн төсөвт байгууллагуудын түлш халаалтын зардалд сэдэвчилсэн аудитыг гүйцэтгээгүй байна. Харин 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Улаанбадрах сумын ЗДТГ, Хөвсгөл сумын ЗДТГ, Соёлын төвийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, шалгалтаар хуурамч бичиг баримт бүрдүүлэн түлш халаалтын зардлаас нийт 1,462.5 мянган төгрөг, Хөвсгөл сумын ЗДТГ нүүрсний үнэд 120.0 мянган төгрөгийг үндэслэлгүй зарцуулсан зөрчилд орон нутгийн төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон байна.

МУ-ын ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 2.3-т “Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино”, Төсвийн тухай хуулийн 37.1.1-т “Төрийн сан төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

Гэтэл дээрх хуулийн заалтуудын хүрээнд төсөвт байгууллагын удирдлагууд болон аймгийн СТСХ, сумдын төрийн сангаас төсөвт байгууллагуудын түлш халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Мөн ЭХЗХ-ны 2018 оны 292 дугаар тогтоолоор батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 6.1-т “Энэхүү дүрмийн биелэлтэд хангагч, хэрэглэгч талууд болон Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч хяналт тавина” гэж заасан.

Аймгийн МХГ-ын эрчим хүчний хяналтын улсын байцаагч нь 2019, 2020 онд дулаанаар хангагч байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл хангуулах, засвар шинэчлэлт, угсралтын чанар байдал, осол аваараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн байх боловч хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангах чиглэлээр хяналт хэрэгжүүлээгүй, 2008 онд батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм” 2018 онд шинэчлэн батлагдсанаас хойш дүрэмд заасны дагуу дулаан ашиглагч байгууллагуудын халаалтын талбайн хэмжээнд хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дээрх хууль, журмуудад ТЕЗ нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг, ТШЗ нь дотоод хяналтын үйл ажиллагааг, Төрийн сан нь төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр тус тус заасан байх боловч холбогдох байгууллага, албан тушаалтнууд түлш халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн байдалд хяналт шалгалт хийгээгүйгээс тухайн зардлыг бодитой төлөвлөх, орон нутгийн төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахгүй байх нөхцөл бий болж байна.

Б.2. Халаалтын талбайн бодит хэмжээ болон нүүрсний хэрэгцээ шаардлагыг зөв тогтоосноор төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх боломж байна.

Б.2.1. Түлш халаалтын зардлын нийт гүйцэтгэлийн 0.8 хувь буюу 87.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулжээ.

Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасан.

Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалд "түлш халаалтын зардалд уурын болон дулааны халаалтад холбогдсон байгууллага үйлчлэгч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу төлөх дулааны эрчим хүч болон халуун усны төлбөр, мөн түүнчлэн ердийн халаалтын зууханд хэрэглэх аргал, түлээ, нүүрс, мод зэрэг түлшинд гарсан зардлыг хамруулна. Түлш бэлтгэхтэй холбоотойгоор гарах тээвэр шатахууны зардлыг энэ ангилалд бүртгэхгүй, тээвэр шатахууны зардалд бүртгэнэ" гэж заажээ.

Аудитад хамрагдсан 2019 онд түлш, халаалтын зардлаас 10 байгууллага 14.5 сая төгрөгийг, 2020 онд 18 байгууллага 72.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Түлш халаалтын зардал нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын бүлгээр хянагдах зардал учир цэвэр бохир усны зардалд болон гэрэл цахилгааны зардалд түлш халаалтын зардлаас шилжүүлсэн төлбөрийг төсвийн зориулалт бус зарцуулалт зөрчлөөр зөвшөөрөөгүй ба харин гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаагүй алдаанд хамруулан /тайлангийн Б.1.1 дэх хэсэг/ авч үзсэн болно.

Төсвийн зориулалт бус зарцуулалт

Хүснэгт №14

/сая төгрөг/

Он	Зардлын зориулалт						нийт
	Дулааны шугамын засвар, үйлчилгээ	Сантехникийн засвар	Материал, хөрөнгө худалдан авалт	Барилгын засвар	Түлээ нүүрсний дэмжлэг	Шатахуун худалдан авалт	
2019	0.6	11.5	1.6	0.8	-	-	14.5
2020	0.8	41.7	0.9	-	29.3	0.2	72.8
Нийт	1.4	53.2	2.5	0.8	29.3	0.2	87.3

Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил нь 2020 онд 2019 оноос 5 дахин нэмэгдсэн байна. Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийн хэмжээг нийт бодит гүйцэтгэлтэй харьцуулахад 2019 онд 0.3 хувь, 2020 онд 1.3 хувийг эзэлж байна.

2019 болон 2020 онд зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийн 63.5 хувь нь урсгал засварын зардлаас, 2.6 хувь нь эд хогшил худалдан авах зардлаас, 33.8 хувь нь тэтгэмж урамшууллын зардлаас зарцуулбал зохих хөрөнгө байна.

Дулаанаар хангагч байгууллагаас үзүүлсэн дулааны шугамын засвар, үйлчилгээний төлбөрийг дулааны нэхэмжлэхэд тусган, түүнийг байгууллагын нягтлан бодогч

График №4



болон төсөв захирагчид урсгал засварын зардлаас шилжүүлэх байтал түлш халаалтын зардлаас зарцуулсан байдал түгээмэл ажиглагдаж байна.

Тухайлбал, 2019 онд 5 байгууллага, 2020 онд 7 байгууллага шилжүүлсэн байна.

Мөн сантехникийн засварын ажилд 2019 онд Эрдэнэ сумын ЗДТГ нь 5.5 сая төгрөг, Замын-Үүд сумын 5 дугаар цэцэрлэг 6.0 сая төгрөг, 2020 онд Даланжаргалан сумын ЕБС 26.9 сая төгрөг, Эрдэнэ сумын ЗДТГ 5.0 сая төгрөг, Саранхөхөө театр 9.7 сая төгрөгийг зарцуулсан ба эдгээр байгууллагад урсгал засварын зардлын төсөв хүрэлцээгүй байна. /График №4/

Түлш халаалтын зардлаас эд хогшил худалдан авах зардалд 2019 онд Сайхандулаан сумын ЗДТГ 0.5 сая төгрөг /зуухны насос/, Сайхандулаан сумын соёлын төв 1.1 сая төгрөг /кондөйшн худалдан авахад 1.0 сая төгрөг, зуух худалдан авахад 0.1 сая төгрөг/, 2020 онд Сайхандулаан сумын соёлын төв 0.5 сая төгрөг /зуух, яндан/, Алтанширээ сумын ЗДТГ 0.2 сая төгрөг /тоолуур/, Дэлгэрэх сумын ЭМТ 0.2 сая төгрөг /халаагуур/ тус тус зарцуулсан байна. Дээрх байгууллагуудын эд хогшил худалдан авах зардлын төсөв, гүйцэтгэлийг хянахад эд хогшил худалдан авах зардал тусгагдаагүй, төсөв хүрэлцээгүй байна.

Түлш халаалтын зардлаас тэтгэмж урамшууллын зардалд 2020 онд Алтанширээ сумын ЗДТГ 5.2 сая төгрөг, ЕБС 16.3 сая төгрөг, соёлын төв 1.9 сая төгрөг, цэцэрлэг 3.5 сая төгрөг, ЭМТ 2.4 сая төгрөгийг /түлээ нүүрсний дэмжлэг/, нийт 29.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны ашиглаж байгаа 144м3 талбайн дулааны төлбөрийг аймгийн ЗДТГ-ын халаалтын талбайд оруулан тооцож тус байгууллагын зардлаас төлбөрийг шилжүүлсэн байна. Аудитаар аймгийн ЗДТГ-ын түлш халаалтын зардлаас илүү шилжүүлж байгаа дулааны төлбөрийг холбогдох байгууллагаар төлүүлэн, зардлын бодит гүйцэтгэлийг тайланд тусгуулах талаар холбогдох албан тушаалтнуудад албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан нь урсгал засвар, эд хогшил худалдан авах зардалд төсөв батлаагүй, батлагдсан төсөв хүрэлцээгүй, түлш халаалтын зардлыг үндэслэлгүйгээр илүү төлөвлөж баталсантай холбоотой байна. Мөн төсвийн шууд захирагч болон нягтлан бодогч, төрийн сангийн мэргэжилтний хариуцлагагүй үйлдэлтэй холбоотой байна.

Түлш халаалтын төсвөөс зориулалт бусаар зарцуулсан 87.3 сая төгрөгийн зардал гарч, үүнээс 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Алтанширээ сумын ЗДТГ-ын албан хаагчдад түлээ, нүүрсний дэмжлэг үзүүлсэн 5.2 сая төгрөг, Эрдэнэ сумын ЗДТГ-ын урсгал засварт зарцуулсан 5.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн байна. Иймд төсвийг зориулалт бусаар зарцуулсан 77.1 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар албан шаардлагыг аймгийн CTCX-т хүргүүлэв.

Б.2.2. Төвлөрсөн дулаанд холбогдоогүй сумд түлээ нүүрсний ХАА-г хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

Төвлөрсөн дулаанд холбогдоогүй сумдын түлш халаалтын зардалд 2019 онд 531.4 сая төгрөг батлагдаж 473.2 сая төгрөгийг зарцуулсан, 2020 онд 1,145.1 сая төгрөгийн төсөв батлагдаж, 901.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Өмнөх онтой харьцуулахад 2020 оны түлш халаалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл өссөн байгаа нь тухайн онд 4 сум төвлөрсөн дулаанд холбогдсонтой холбоотой байна.

Сумдын түлээ, нүүрсний зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэл

Хүснэгт №15

/сая төгрөг/

№	Сумдын нэр	Батлагдсан төлөвлөгөө		Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх гүйцэтгэл	
		2019 он	2020 он	2019 он	2020 он
1	Алтанширээ сум	56.6	243.4	58.2	146.8
2	Даланжаргалан сум	87.6	221.4	73.5	208.4
3	Дэлгэрэх сум	92.4	207.8	92.4	161.6
4	Мандах сум	39.5	51.4	42.5	50.8
5	Сайхандулаан сум	35.8	34.2	35.3	31.2
6	Улаанбадрах сум	96.9	105.4	56.0	83.9
7	Хатанбулаг сум	69.7	189.3	64.1	143.6
8	Хөвсгөл сум	52.9	92.1	51.5	74.8
	ДҮН	531.4	1,145.1	473.2	901.1

Түлээ нүүрсний худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал:

МУ-ын ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журамд заасан босго үнээс давсан бараа, ажил үйлчилгээг худалдан авахад тендер шалгаруулалтыг зохион байгуулахаар заасан.

Аудитад хамрагдсан хугацаанд төвлөрсөн дулаанд холбогдоогүй 8 сумын 39 байгууллага түлш халаалтын зардлын батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулах ХАА-ны журмын төрлийг доорх хүснэгтэд харуулав. /Дэлгэрэнгүйг хавсралт №6-д харуулав/

Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй сумдын нүүрсний худалдан авах ажиллагаа зохион байгуулах төрөл

Хүснэгт №16

№	Аудитад хамрагдах он	ХАА зохион байгуулах байгууллагын тоо	НТШ	Харьцуулалтын арга	ШГБ
1	2019 он	38	1	11	26
2	2020 он	36	2	23	11

Аудитад хамрагдсан 2019 онд 8 сумын 38 байгууллагаас 12 байгууллага 266.6 сая төгрөгийн НТШ, харьцуулалтын аргаар ХАА-г зохион байгуулах байтал Дэлгэрэх сумын Цэцэрлэг, Хөвсгөл сумын ЕБС-иас бусад байгууллагууд ХАА зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулсан байна.

2020 онд 36 байгууллагаас 25 байгууллага нь 840.5 сая төгрөгийн ХАА-г зохион байгуулах байтал 2020 онд Дэлгэрэх сумын 5 байгууллага, Хөвсгөл сумын ЕБС, ЭМТ, Соёлын төв, нийт 8 байгууллагаас бусад байгууллага ХАА-г зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулан түлээ нүүрс худалдан авсан байна.

Түлээ нүүрсний ХАА-г зохион байгуулахдаа байгууллагууд дараах зөрчлийг гаргасан байна. Үүнд:

- Дэлгэрэх сумын ЕБС 2019 онд 51.9 сая төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулах байсан боловч сумын хэмжээнд худалдан авах ажиллагааны сертификаттай албан хаагч байхгүй шалтгаанаар зохион байгуулаагүй.
- Дэлгэрэх сумын Соёлын төв 2020 онд харьцуулалтын аргаар ХАА зохион байгуулж, Дэртийн булаг ХХК-ийг шалгаруулан 2020.10-2022.12 дугаар сарын хооронд 3 жилийн хугацаатай гэрээ байгуулсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6.1-т “ХАА-ны ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.
- 2020 онд Улаанбадрах сумын ЕБС 4,1 сая төгрөг, Цэцэрлэг 0,7 сая төгрөг, нийт 4.8 сая төгрөгийн түлээ нүүрс худалдан авахдаа бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулаагүй байна.
- Аудитад хамрагдсан онуудад сумдын байгууллагууд нийт 32 нийлүүлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй гэрээ байгуулсан боловч тус гэрээнд нийт хэдэн тонн нүүрсийг, ямар үнэ ханшаар нийлүүлэх талаар тусгаагүй байна.

Түлш халаалтын зардлын батлагдсан төсвийг зарцуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу ХАА-г зохион байгуулж, орон нутгийн төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаар сумдын төсөвт байгууллагуудын удирдлагуудад чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулж ажиллах.

Түлээ, нүүрсний зарцуулалт:

Төвлөрсөн халаалтад холбогдоогүй 8 сумын, 38 байгууллагын түлш халаалтын зардлын зарцуулалтыг авч үзэхэд 2019 онд 411.9 сая төгрөгийн нүүрс худалдан авч, 403.4 сая төгрөгийн зарцуулалттай, 2020 онд 368.9 сая төгрөгийн түлш худалдан авч, зарцуулалт 368.2 сая төгрөг байна.

**Бараа материалын тайлангаарх 2019, 2020 оны
түлээ нүүрсний зарцуулалт**

Хүснэгт №17

/сая төгрөг/

Он	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
2019	149.0	411.9	403.4	157.5
2020	157.5	368.9	368.2	158.2
Зөрүү	8.5	-43.0	-35.2	0.7

Түлээ нүүрсний зарцуулалтын өсөлт, бууралтыг авч үзвэл 2020 онд өмнөх оноос 17 байгууллагын зардал нийт дүнгээр 53.2 сая төгрөгөөр нэмэгдэж, 22 байгууллагын зардал 88.3 сая төгрөгөөр буурсан байна. /Хавсралт №7-д харуулав/

Алтанширээ, Даланжаргалан, Улаанбадрах, Хатанбулаг сумдыг 2020 онд төвлөрсөн халаалтад холбохоор төлөвлөснөөс тус оны түлш халаалтын зардлыг өмнөх оноос 613.7 сая төгрөгөөр буюу 53.6 хувиар нэмэгдүүлэн баталсан байна.

**Түлээ нүүрсний зардлын төсвийн төсөл, батлагдсан төсөв,
гүйцэтгэлийн харьцуулалт**

Хүснэгт №18

/сая төгрөг/

Он	Өмнө оны гүйцэтгэл	Төсвийн төсөлд тусгасан	АИТХ-аар баталсан	ТГТ-аар гүйцэтгэл	Нэмэгдсэн, хасагдсан өөрчлөлт		
	1	2	3	4	5=1-2	6=3-2	7=4-3
2019	417.0	861.4	531.4	473.2	444.4	-330.0	-58.1
2020	473.2	1,423.2	1,145.1	901.1	950.0	-278.2	-244.0
Зөрүү	56.2	561.9	613.7	427.9			

Түлш халаалтын зардлын батлагдсан төсвийг бараа материалын тайлангийн зарцуулалттай харьцуулахад 2019 онд 531.4 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас 411.9 сая төгрөгийн нүүрс худалдан авч, 403.4 сая төгрөгийн түлээ нүүрс зарцуулан, 119.5 сая төгрөг хэмнэсэн байна.

Харин 2020 онд 1,145.1 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас 368.9 сая төгрөгийн нүүрс худалдан авч, 368.2 сая төгрөгийн түлээ нүүрс зарцуулан, 776.2 сая төгрөгийн зардал хэмнэсэн байх ба энэ нь Алтанширээ, Даланжаргалан, Улаанбадрах, Хатанбулаг сумд 2020 оны 10 дугаар сараас төвлөрсөн дулаан хангамжид холбогдсоноос түлээ нүүрсний зарцуулалт буурсантай холбоотой байна.

МУ-ын Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасан.

Гэтэл аймаг, сумдын ИТХ-аар түлш халаалтын зардлыг батлахдаа сумдын байгууллагуудын халаалтын горим, барилга, байгууламжийн хэмжээ, нүүрсний зах зээлийн үнэд өөрчлөлт ороогүй нөхцөл байдлыг харгалзан үзэхгүйгээр түлш, халаалтын зардлыг нэмэгдүүлэн баталснаас байгууллагууд бодит хэрэгцээнээс илүү хэмжээний худалдан авалт хийсэн байна. Тухайлбал:

- Дэлгэрэх сумын ЕБС-ын түлш халаалтын зардлын 2019 оны гүйцэтгэл 59.6 сая төгрөг, барилга байгууламжид өөрчлөлт ороогүй байхад тус зардлын төсвийг 112.5 сая төгрөгөөр баталж, 2020 онд өмнөх оны үнээр 125 тонн, үүнээс хямд үнээр 765 тонн буюу нийт 87.7 сая төгрөгийн нүүрс худалдаж авсан.
- Дэлгэрэх сумын ЗДТГ-ын түлш халаалтын зардлын 2019 оны гүйцэтгэл 4.8 сая төгрөг, барилга байгууламжид өөрчлөлт ороогүй байхад тус зардлын төсвийг 18.1 сая төгрөгөөр баталж, 2020 онд өмнөх оны үнээр 17.6 сая төгрөгийн, 146.6 тонн нүүрс худалдаж авсан.

- Дэлгэрэх сумын ЭМТ-ийн түлш халаалтын зардлын 2019 оны гүйцэтгэл 7.7 сая төгрөг, барилга байгууламжид өөрчлөлт ороогүй байхад тус зардлын төсвийг 21.8 сая төгрөгөөр баталж, 2020 онд өмнөх оны үнээр 17.3 сая төгрөгийн, 146.9 тонн нүүрс худалдаж авсан.
- Хөвсгөл сумын ЕБС-ийн түлш халаалтын зардлын 2019 оны гүйцэтгэл 18.3 сая төгрөг, барилга байгууламжид өөрчлөлт ороогүй байхад тус зардлын төсвийг 30.7 сая төгрөгөөр баталж, 2020 онд өмнөх оны дундаж үнээр 24.5 сая төгрөгийн, 181.8 тонн нүүрс худалдаж авсан.

Аудитад хамрагдсан онуудын түлээ нүүрсний зарцуулалт дараах байдал байдалтай байна.

**Бараа материалын тайлангаарх 2019, 2020 оны
түлээ нүүрсний зарцуулалтын харьцуулалт**

Хүснэгт №19		/сая төгрөг/		
№	Байгууллагын нэр	Түлээ нүүрсний зарцуулалт		Өсөлт
		2019 он	2020 он	
1	Дэлгэрэх сумын ЗДТГ	4,814.0	17,448.0	12,634.0
2	Дэлгэрэх сумын Соёлын төв	1,991.0	13,104.0	11,113.0
3	Мандах сумын ЗДТГ	7,742.0	10,887.8	3,145.8
4	Мандах сумын ЕБС	12,865.0	14,247.7	1,382.7
5	Мандах сумын Соёлын төв	2,950.0	5,153.0	2,203.0
6	Мандах сумын ЭМТ	3,650.0	5,201.0	1,551.0
7	Сайхандулаан сумын ЗДТГ	4,557.0	7,153.2	2,596.2
8	Сайхандулаан сумын ЕБС	11,527.0	12,397.0	870.0
9	Хөвсгөл сумын ЗДТГ	5,732.1	7,183.0	1,450.9
10	Хөвсгөл сумын ЕБС	18,392.4	16,405.5	-
Нийт дүн		74,220.5	109,180.2	36,946.6

Мандах, Сайхандулаан, Хөвсгөл сумдын 10 байгууллагын түлээ нүүрсний зарцуулалтыг өмнөх онтой харьцуулахад 9 байгууллага 36.9 сая төгрөгөөр өссөн ба дараах шалтгаанаар өссөн байна. Үүнд:

- Дэлгэрэх сумын Соёлын төвийн зарцуулалт өссөн нь шинээр спортын цогцолбор баригдсан.
- Дэлгэрэх сумын ЗДТГ 2019 оны 10, 11, 12 дугаар сард зарцуулсан түлээ нүүрсний зарцуулалтыг тус онд тайлагнаагүй ба 2020 оны 01 дүгээр сард залруулж бараа материалын тайланд тусгасан
- Мандах сумын ЗДТГ-ын өргөтгөлийн барилга 2020 оны 11 дүгээр сард ашиглалтад орж халаах талбайн хэмжээ нэмэгдсэн.
- Мандах сумын ЕБС 2019 онд 12.9 сая төгрөгийн 136.4 тонн нүүрс, 2020 онд 14.2 сая төгрөгийн 131.1 тонн зарцуулж байгаа нь нүүрсний үнэ өссөн.
- Мандах сумын Соёлын төв 2019 оны 11 дүгээр сараас шинээр нам даралтын зуухаар галлаж эхэлсэнтэй холбоотой өдөрт зарцуулах нүүрсний хэмжээ ихэссэнээр 2020 оны зарцуулалт өссөн.
- Мандах сумын ЭМТ ашиглалтгүй байсан өрөөг ашиглалтад оруулан халаалтын шугам суурилуулсан.
- Сайхандулаан сумын ЗДТГ нь буудлын өрөөнүүдийг тусгаарлах байрны зориулалтаар ашиглахдаа ЗДТГ-ын худалдан авсан нүүрснээс зарцуулсан.

- Сайхандулаан сумын ЕБС 2020 онд галлагаандаа түлээний мод худалдаж авсан.
- Хөвсгөл сумын ЗДТГ 2020 онд Цагдаагийн тасгийг галласнаас түлээ нүүрсний зарцуулалт өссөн байна.

Аудитад хамрагдсан хугацааны түлээ нүүрсний үлдэгдлийг тухайн жилийн зарцуулалттай нь харьцуулж үзэхэд дараах байдалтай байна

Бараа материалын тайлангаарх түлээ нүүрсний үлдэгдэл болон зарцуулалтын харьцуулалт

Хүснэгт №20

/сая төгрөг/

№	Байгууллагын нэр	2019 он		2020 он		2020 оны зарцуулалтад үлдэгдлийн эзлэх хувь
		Түлээ, нүүрсний жилийн зарцуулалт	2019.12.31-ний үлдэгдэл	Түлээ, нүүрсний жилийн зарцуулалт	2020.12.31-ний үлдэгдэл	
1	Дэлгэрэх сумын ЕБС	59.6	6.5	58.8	35.3	60.1
2	Дэлгэрэх сумын Соёлын төв	2.0	1.6	13.1	6.8	52.2
3	Дэлгэрэх сумын Цэцэрлэг	19.0	9.9	18.1	10.3	57.0
4	Дэлгэрэх сумын ЭМТ	7.8	0.6	13.6	4.3	31.4
5	Мандах сумын ЗДТГ	7.7	6.5	10.9	11.9	109.4
6	Мандах сумын ЕБС	12.9	10.4	14.2	12.2	85.3
7	Мандах сумын Цэцэрлэг	5.9	4.4	5.7	3.2	56.4
8	Мандах сумын ЭМТ	3.7	1.5	5.2	6.2	120.0
9	Сайхандулаан сумын ЕБС	11.5	5.6	12.4	4.7	38.1
10	Сайхандулаан сумын Соёлын төв	4.4	3.2	4.9	3.6	72.1
11	Сайхандулаан сумын ЭМТ	6.8	3.0	6.7	2.6	39.1
12	Хөвсгөл сумын ЗДТГ	5.7	5.6	7.2	7.0	97.1
13	Хөвсгөл сумын ЕБС	18.4	-	16.4	8.1	49.2
14	Хөвсгөл сумын Соёлын төв	11.2	6.5	12.9	13.3	103.7
15	Хөвсгөл сумын Цэцэрлэг	7.7	4.6	8.4	5.2	61.7
16	Хөвсгөл сумын ЭМТ	6.5	4.1	7.9	9.3	116.9
Нийт дүн		190.8	74.0	216.4	144.0	66.5

2020 оны жилийн эцсийн бараа материалын тайланд их хэмжээний түлээ нүүрсний үлдэгдэлтэй тайлагнагдсан 16 байгууллагын үлдэгдлийг аудитад хамрагдсан хугацааны зарцуулалттай харьцуулж үзэхэд 2019 онд нийт 190.8 сая төгрөгийн нүүрс зарцуулж 74.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй, энэ нь нийт зарцуулалтын 38.8 хувь, 2020 онд нийт 216.4 сая төгрөгийн нүүрс зарцуулж, 144.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тус үлдэгдэл нь нийт зарцуулалтын 66.5 хувийг эзэлж байна.

Хэрэгцээнээс илүү хэмжээний худалдан авалт хийж, их хэмжээний нүүрс нөөцөлсөн нь тухайн байгууллагын дараа жилийн зарцуулалтын дийлэнх хувийг хангахаар байгаа нь ирэх жилийн батлагдсан төсвийг үр дүнтэй зарцуулахгүй байх, удаан хугацаагаар хадгалах нь нүүрсний чанар байдалд нөлөөлөх, хадгалах агуулах савгүйгээс нүүрс алдагдах зэргээр түлш халаалтын зардлыг үр ашиггүй зарцуулах нөхцөл үүсэж байна.

Алтанширээ, Даланжаргалан, Хатанбулаг, Улаанбадрах сумдын нийт 19 байгууллага 2020 онд төвлөрсөн дулаанд холбогдож, Алтанширээ, Хатанбулаг сумд Чандмань-Илч ОНӨХХК-тай, Даланжаргалан сумын төсвийн 4 байгууллага БАҮ-ний III ангитай, Улаанбадрах сумын 5 байгууллага "СИЗУ" ХХК-тай дулаанаар хангах гэрээ байгуулан ажиллаж байна.

Дээрх сумдын төвлөрсөн дулаанд холбогдож, дулаанаар хангагдах гэрээ байгуулсан хугацаагаар тасалбар болгосон түлээ нүүрсний үлдэгдлийг авч үзэхэд дараах байдалтай байна.

Төвлөрсөн халаалтад холбогдсон сумдын түлээ нүүрсний үлдэгдэл

Хүснэгт №21

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Дулаанаар хангах гэрээ байгуулсан огноо	2020 оны үлдэгдэл	
			Нүүрсний хэмжээ /тонн/	Мөнгөн дүн
1	Алтанширээ сумын ЗДТГ	Гэрээ байхгүй	30 шуудай	435.0
2	Улаанбадрах сумын ЗДТГ	2020.11.27	31.2	4,056.0
3	Улаанбадрах сумын ЕБС	2020.11.27	8.0	1,087.5
4	Улаанбадрах сумын Цэцэрлэг	2020.11.27	5.0	650.0
5	Улаанбадрах сумын ЭМТ	2020.11.27	12.0	1,500.0
6	Хатанбулаг сумын Соёлын төв	Гэрээ байхгүй	20.1	1,632.6
Нийт дүн				9,361.1

Төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон дээрх 6 байгууллагын 9.4 сая төгрөгийн түлээ нүүрсний үлдэгдлийг шийдвэрлүүлэх талаар холбогдох албан тушаалтнуудад албан шаардлага хүргүүлжээ. /Тус үлдэгдлээс Алтанширээ сумын ЗДТГ 435.0 мянган төгрөгийн үлдэгдлийг ковид-19 өвчний цар тахлын нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын 5 чиглэлийн постын галлагаанд зарцуулсан байна/

2020 оны байдлаар галлагаагаар халааж байгаа сумдын байгууллагуудыг төвлөрсөн дулаанд холбоход түлш халаалтын зардлын төсөвт гарах өөрчлөлтийг тооцож үзэхэд дараах байдалтай байна. /Зардлын дэлгэрэнгүйг хавсралт№8-д харуулав/

Сумдын төсөвт байгууллагуудыг галлагаагаар халаах болон төвлөрсөн дулаанд холбоход гарах зардлын тооцоо

Хүснэгт №22

/сая төгрөг/

№	Байгууллагын нэр	Нүүрс түлэхэд гарах зардлын тооцоо /2020 оны байдлаар/	Төвлөрсөн халаалтад холбогдоход гарах зардлын тооцоо	Зөрүү	
				Өссөн	Буурсан
1	Дэлгэрэх сум ЗДТГ	35.0	24.5	-	10.6
2	Дэлгэрэх сум ЭМТ	23.5	20.4	-	3.1
3	Дэлгэрэх сум Цэцэрлэг	33.0	22.6	-	10.4
4	Дэлгэрэх сум Соёлын төв	21.2	34.7	13.5	-
5	Дэлгэрэх сум Сургууль	66.3	102.8	36.5	-
6	Мандах сумын ЗДТГ	25.2	21.8	-	3.3
7	Мандах сумын Соёлын төв	19.7	50.2	30.5	-
8	Мандах сумын ЕБС	40.0	106.6	66.7	-
9	Мандах сумын ЭМТ	12.5	41.7	29.2	-
10	Мандах сумын Цэцэрлэг	36.1	28.9	-	7.2
11	Сайхандулаан сум ЗДТГ	18.6	19.6	1.0	-
12	Сайхандулаан сумын ЭМТ	15.9	10.5	-	5.4
13	Сайхандулаан сумын ЕБС	22.0	131.5	109.5	-
14	Сайхандулаан сумын Соёлын төв	7.9	36.8	28.9	-
15	Хөвсгөл сумын ЗДТГ	21.0	24.1	3.1	-
16	Хөвсгөл сумын ЭМТ	19.3	21.6	2.3	-
17	Хөвсгөл сумын ЕБС	34.0	101.0	67.0	-
18	Хөвсгөл сумын Цэцэрлэг	25.3	18.0	-	7.3
19	Хөвсгөл сумын Соёлын төв	25.8	131.4	105.6	-
Нийт дүн		502.3	948.6	493.7	47.4

/ЭХЗЗ-ийн 2020/12/30-ны өдрийн 07 тогтоолоор баталсан Чандмань-Илч ОНӨХХК-ний Хатанбулаг, Алтанширээ, Улаанбадрах сумдад баримтлах тарифыг үндэслэсэн болно/

Сумдын төсөвт байгууллагуудыг төвлөрсөн дулаанд холбоогүй байхад 2020 оны байдлаар нийт 502,3 сая төгрөгийг зардлын гүйцэтгэл гарсан ба дулаанд холбосон тохиолдолд 948,6 сая төгрөгийн зардал гарч, түлш халаалтын зардал нийт дүнгээр 446,3 сая төгрөгөөр өсөх тооцоотой байна.

Харин халаалтын талбайн хэмжээнээс хамаарч түлш халаалтын зардал өсөж, буурахаар байна. Тухайлбал, бага буюу 1822,9 м³ эзлэхүүнтэй Дэлгэрэх сумын ЗДТГ нь түлээ нүүрс худалдан авах болон галч нарын цалингийн зардалд жилд нийт 35.0 сая төгрөгийг зарцуулж байсан бол төвлөрсөн дулаанд холбосноор жилд ойролцоогоор 24.5 сая төгрөгийг зарцуулж, 10.5 сая төгрөгийг хэмнэхээр байна. Мөн 9869.8 м³ эзлэхүүнтэй Сайхандулаан сумын ЕБС галлагаатай холбоотой зардалд жилд 22.0 сая төгрөгийг зарцуулдаг ба төвлөрсөн дулаанд холбогдвол

ойролцоогоор жилд 131.5 сая төгрөгийг зарцуулж түлш халаалтын зардал 109.5 сая төгрөгөөр өсөхөөр байна.

Галлагаатай сумдыг төвлөрсөн дулаанд холбосноор түлш халаалтын зардал өсөхөөр байгаа ч галлагаатай байх үед үүсдэг нүүрсний хадгалалт, хамгаалалт, дутагдал үүсэх эрсдэл багасаж, үр ашиггүй зарцуулалт багасах төдийгүй тухайн байгууллагын ажилтнуудын ажиллах орчин нөхцөл сайжрах боломж бүрдүүлэхээр байна.

Алтанширээ сумын ЕБС-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын ажиллагсдад нийт 27 тонн нүүрс олгож, түлш халаалтын зардлаас 2,700.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан зөрчилд албан шаардлага тогтоосон байна.

Б.2.3. ЭХЗХ-ны 2018 оны 292 тогтоолоор батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм”-д заасны дагуу төсөвт байгууллагуудын халаалтын талбайн хэмжээг шинэчлэн тогтоогоогүй байна.

Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн 2008 оны 158 дугаар тогтоолоор батлагдсан “Дулааны эрчим хүчний төлбөр тооцооны журам”-ын 3.3-т “Аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдсан барилга, объектын халаалтын төлбөр тооцох эзлэхүүнийг тогтоохдоо тухайн барилгын гадна болон өрөөний хана, тааз, шалны зузааны тэнхлэгээс эсрэг талын гадна болон өрөөний хана тааз, шалны зузааны тэнхлэг хүртэлх зайгаар тодорхойлно. Анхны батлагдсан зургаас өөр зориулалтаар уг барилгыг ашиглах бол мэргэжлийн байгууллагын дүгнэлт, дулааны эрчим хүчээр найдвартай хангах техникийн хувьд боломжтой эсэх тооцоог үндэслэн эх үүсвэрийг тогтооно” гэж заасан.

Дээрх дүрмийг ЭХЗХ-ны 2018 оны 292 дугаар тогтоолоор “Дулаанаар зохицуулалттай хангах тусгай Зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийг шинэчлэн баталсан ба тус дүрмийн 5.3.1-т “Аливаа барилга байгууламж, орон сууц нь дулааны тоолуур суурилагдаагүй бол дулааны эрчим хүчний төлбөр тооцоог энэхүү дүрэмд заасны дагуу эзлэхүүн болон талбайн хэмжигдэхүүнээр гэрээний дагуу тооцно”, 5.3.4-т “Аж ахуйн үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдсан барилгад, дулааны тоолуур суурилуулах боломжгүй тохиолдолд халаалтын төлбөрийг эзлэхүүнээр тооцно. Тухайн барилгын халаалтын төлбөр тооцох эзлэхүүнийг өрөөний урт, өргөн, өндөр/давхрын бодит өндөр/-ийн хэмжээгээр тодорхойлно” гэж заасан.

Гэтэл халаалтын талбайг тооцох аргачлал шинэчлэгдэн батлагдсанаас хойш дулаанаар хангагч тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд нь нийт төсөвт байгууллагуудын халаалтын талбайн хэмжилтийг журмын дагуу дахин шинэчилж хэмжээгүй, шинээр ашиглалтад орсон зарим барилга, байгууламжийн халаалтын талбайг барилгын зурагт тусгасан эзлэхүүнийг үндэслэн тогтоосон байна.

Дулааны шугам сүлжээнд холбогдсон ТЕЗ-ийн харьяа нийт 94 төсөвт байгууллага нь УБТЗ-ын ХНН Барилга ашиглалт үйлчилгээний III анги, Чандмань-Илч ОНӨХХК, Чандмань бадрал ОНӨХХК, СИЗУ ХХК-тай дулаанаар хангах гэрээ байгуулан ажиллаж байна.

Аудитаар Сайншанд, Замын-Үүд, Улаанбадрах сумдын нийт 26 байгууллагыг түүвэрт хамруулан, барилга байгууламжийн талбайд хэмжилт хийсэн болно.

Түүвэрт хамрагдсан байгууллагуудын дулааны талбайн харьцуулалт

Хүснэгт №23

№	Төсөвт байгууллагын нэр	2020 оны дулаанаар хангах гэрээнд заасан хэмжээ м³	ГХБХБГ-аас ирүүлсэн судалгаа м³	Аудитаар хэмжсэн талбайн хэмжээ м³	Зөрүү	
					Өссөн	Буурсан
А	Б	1	2	3	4=3-1	
Сайншанд сум						
1	1-р цэцэрлэг	1,949	1,949	1,811	-	137
2	3-р цэцэрлэг	3,131	-	2,682	-	448
3	5-р цэцэрлэг	3,092	1,892	2,222	-	869
4	6-р цэцэрлэг	3,640	-	2,600	-	1,039
5	8-р цэцэрлэг	3,019	-	2,078	-	940
6	10-р цэцэрлэг	3,953	5,018	3,527	-	425
7	Агатова өрхийн эмнэлэг	1,080	-	539	-	540
8	Мишээлт мана өрхийн эмнэлэг	1,080	-	539	-	540
9	СШ сумын 1-р баг	540	1,031	631	91	-
10	СШ сумын 2-р баг	540	1,031	631	91	-
11	СШ сумын 6-р баг	540	1,031	631	91	-
12	СШ сумын 8-р баг	540	1,031	631	91	-
13	12 дугаар цэцэрлэг	5,096	5,096	4,924	-	171
Дүн		28,200	18,082	23,452	364	5,114
Замын-Үүд сум						
1	ЗДТГ	4,008	-	1,858	-	2,149
2	Соёл спортын ордон	8,463	10,640	9,181	718	-
3	2-р сургууль	18,833	22,803	15,435	-	3,397
4	3-р сургууль	25,553	25,553	19,740	-	5,812
5	1-р цэцэрлэг	7,637	-	3,336	-	4,300
6	4-р цэцэрлэг	3,812	-	3,905	93	-
7	5-р цэцэрлэг	5,047	5,661	4,687	-	359
8	6-р цэцэрлэг	2,049	-	1,986	-	62
Дүн		75,404	64,658	60,133	811	16,083
Улаанбадрах сум						
1	Соёлын төв	7,212	-	6,416	-	796
2	ЗДТГ	914	-	684	-	230
3	ЕБСургууль	6,534	-	4,349	-	2,185
4	Цэцэрлэг	2,150	-	1,258	-	892
5	ЭМТ	1,444	-	983	-	460
Дүн		18,254		13,692		4,562
Нийт дүн		121,859	82,740	97,277	1,177	25,759

Хэмжилтээр нийт 26 байгууллагын 25,759 м³ талбайг илүү тооцож 302.8 сая төгрөг илүү, 1,177 м³ талбайг дутуу тооцсоноос 14.6 сая төгрөг дутуу, жилдээ нийт 288.3 сая төгрөгийн түлш халаалтын зардлыг илүү зарцуулсан тооцоо гарч байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. ЭХЗЗ нь 2019, 2020 онуудад 3 аж ахуйн нэгж, байгууллагад дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл олгохдоо хүсэлт гаргагчдаас ирүүлсэн дутуу материалд үндэслэн тусгай зөвшөөрөл олгосон байна.
2. ЭХЗЗ-өөс орон нутагт дулаанаар хангах тусгай зөвшөөрөл олгогдоогүй, үнэ тариф батлагдаагүй байхад дулаан түгээх үйл ажиллагааг эрхлэн явуулсан зөрчил гарсан байна.
3. Төсөвт байгууллагууд түлш халаалтын зардлыг төлөвлөхдөө халаалтын талбайн хэмжээг 2019 онд 890 м³, 2020 онд 26912 м³ талбайг илүү, халаалтын зардлыг тухайн оны бодит гүйцэтгэлээс 2019 онд 1025.8 сая төгрөгөөр, 2020 онд 619.9 сая төгрөгөөр тус тус илүү төлөвлөсөн байна.
4. Аймгийн СТСХ нь ТЕЗ-ийн төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах ажлыг зохион байгуулах, ТЕЗ-ийн харьяа төсвийн байгууллагаас ирүүлсэн төсвийн төслийг холбогдох эдийн засгийн тооцоо, судалгаан дээр үндэслэн нэгтгэн боловсруулах чиг үүргүүдийг хангалтгүй хэрэгжүүлснээс түлш халаалтын зардлыг бодитой төлөвлөж, батлуулаагүй байна.
5. Түлш халаалтын зардлын бодит гүйцэтгэл 2019 онд 4,821.1 сая төгрөг, 2020 онд 5,520.6 сая төгрөг байхад төсвийн гүйцэтгэлийн тайланд 2019 онд 69.6 сая төгрөгөөр, 2020 онд 247.4 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна.
6. Төсвийн гүйцэтгэлийг аудитад хамрагдсан онуудад зөрүүтэй тайлагнаснаар тайлант хугацааны санхүүгийн тайланд төсвийн хэтрэлтийг 52.9 сая төгрөгөөр, төсвийн хэмнэлтийг 190.5 сая төгрөгөөр бууруулж, зөрүүтэй тусгаж тайлагнасан байна.
7. Түлш халаалтын зардлын 9.5 сая төгрөгийн авлага, өр төлбөрийн санхүүгийн тайланд тусгаагүй, 6.4 сая төгрөгийн авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.
8. Түлш халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл болон дулаанаар хангах үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудаас чиглэсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна.
9. Түлш халаалтын зардлын төсвөөс 2019, 2020 онуудад нийт 87.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
10. Төвлөрсөн дулаанд холбогдоогүй сумдын 2019 онд 10 байгууллага 231.3 сая төгрөгийн, 2020 онд 17 байгууллага 565.6 сая төгрөгийн нүүрсний ХАА-г зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан байна.
11. Аудитаар 26 байгууллагыг түүвэрт хамруулан, барилга байгууламжийн талбайд хэмжилт хийхэд нийт 26 байгууллагын талбайг 25,759 м³-ээр зөрүүтэй тооцож жилийн туршид 288.3 сая төгрөгийн түлш халаалтын зардалд илүү зарцуулсан байна.

Аудитаар нийт 3,502.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 91.5 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтнуудад 9 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т заасны дагуу ТЕЗ-төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл, үр ашигт чиглэсэн хяналт шалгалтыг дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулж хэрэгжүүлэх.
2. Түлш халаалтын зардлын батлагдсан төсвийг зарцуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу ХАА-г зохион байгуулж, орон нутгийн төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаар сумдын төсөвт байгууллагуудын удирдлагуудад чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулж ажиллах.

АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.СОДХҮҮ ТАНАА:

1. ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын ТШЗ болон санхүүгийн ажилтнуудад түлш халаалтын зардлын төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах чиг үүргийг хэрэгжүүлэх тухай зөвлөмжөөр хангаж ажиллах.
2. Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн СТС-ын ажилтны ажил үүргийн жишиг заавар”-т заасны дагуу ТЕЗ-ийн төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, эдийн засгийн тооцоо, судалгаан дээр үндэслэн нэгтгэн боловсруулах ажлыг чанаржуулах, холбогдох мэргэжилтнүүдийг хариуцлагажуулж, зардлын төсвийг үр ашигтай төлөвлөж, батлуулах.
3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд түлш халаалтын зардлын гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийг бодит гарсан гүйцэтгэлээр үнэн зөв тусгаж, тайлагнаж байх.
4. Санхүүгийн тайланд авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж тусгах талаар нягтлан бодогчдыг зөвлөмж чиглэлээр хангаж, хяналт тавьж ажиллах.
5. ЭХЗХ-ны хорооны 2018 оны 292 дугаар тогтоолоор батлан, “Дулаанаар зохицуулалттай хангах тусгай Зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-д заасны дагуу ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын халаалтын талбайд бодит хэмжилт хийх ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

**АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА С.ОДБАЯР
ТАНАА:**

1. ЭХЗХ-ны 2019 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 3.1-т заасан баримт бичгийн бүрдлийг хангуулж, хуулиар тогтоосон эрхийн дагуу тусгай зөвшөөрлийг олгож байх.
2. Тусгай зөвшөөрөлгүй, үндэслэлгүй үнэ тарифаар дулаан түгээх үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд эрчим хүчний хангамжийн төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу хяналт хэрэгжүүлж, арга хэмжээ авах, орон нутагт явуулах үйл ажиллагааныхаа цар хүрээг нэмэгдүүлж ажиллах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

№1

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,

Утас /факс: (705) 2-31-31

2021-07-01 № 18
танай 2021-07-01 -ны № 1-6/447 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

Тайлбар хүргүүлэх тухай

Танай 1-6/447 албан бичигт заасны дагуу “Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл” сэдэвт аудитын тайлантай танилцлаа.

1. “СИЗУ” ХХК-нд 2018 онд Эрдэнэ суманд дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах тусгай зөвшөөрөл олгосон. 2020 онд “Дорноговийн Эрдэнэ” ХХК-ийн нэр дээр тусгай зөвшөөрөл хүссэн бөгөөд бичиг баримт бүрдүүлэлт шаардлага хангахгүй байсан тул тусгай зөвшөөрөл олгоогүй. Иймд “СИЗУ” ХХК-ний тусгай зөвшөөрлийн хүрээнд дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах үйл ажиллагааг хариуцан ажилласан.
2. “СИЗУ” ХХК нь Улаанбадрах суманд үйл ажиллагаа явуулах, үнэ тариф батлуулах тусгай зөвшөөрлийн хүсэлтийг ирүүлээгүй мөн улсын комисс тус ажлыг хүлээж аваагүй болно.
3. Г.Эрдэнэцэцэг нь ЭХЗЗөвлөлийн даргын үүрэгт ажлаас 2020 оны 07 сарын 31-ний өдөр чөлөөлөгдөн 2020 оны 12 сарын 17-ны өдөр зөвлөлийн дарга томилогдсон бөгөөд үнэ тариф, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шийдвэр 2020 оны 12 сарын 30-ны өдөр гарсан болно.

Тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ДАРГА



С. ОДБАЯР

№2



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн ирүүлсэн саналд:

1. МУ-ын Эрчим хүчний тухай хуулийн 11.3.2-т “ЭХЗЗ нь тухайн орон нутагт олгосон тусгай зөвшөөрлийнхөө нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хянах”, 11.3.3-т “Зохицуулах зөвлөлийн баталсан аргачлал, журмын дагуу харьяалах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тариф, хэрэглэгчийн үнийг батлах, шалгах, нийтлэх эрх, үүрэгтэй”, 16.1-т “Цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд тухайн тодорхой нутаг дэвсгэрт цахилгаан, дулаан түгээх үйл ажиллагаа явуулах эрх олгоно”, 27.1-т “Хангагчаас үзүүлж байгаа үйлчилгээний үнийг жил бүр, тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдол бүрд хянана” гэж заасан байна.

Аймгийн ЭХЗЗ нь Эрчим хүчний хуульд заасан дээрх заалтуудын дагуу чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий ч тусгай зөвшөөрөл олгогдоогүй аж ахуйн нэгж байгууллага, батлагдаагүй үнэ тарифаар дулаанаар хангах үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа байдлыг таслан зогсоох, дулаанаар хангагч байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг тухай бүр шийдвэрлэн баталгаажуулаагүй зэрэг хууль, журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй нь аудитаар нотлогдож, энэ талаар тайлангийн төсөлд тусгасан тул аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй юм.

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2021 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/620

Дорноговь аймаг, Сайншанд сум

**Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай**

Монгол Улсын Төрийн Аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралтын 1.3, 2.4, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2021 оны А/28 дугаар тушаал “Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагуудыг хавсралтаар баталсугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга, СТСХ-ийн дарга, ЭХЗЗ-ийн дарга нарт тус тус зөвлөсүгэй.
4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, аймгийн ЭХЗЗ-ийн дарга нарт хүргүүлсүгэй.
5. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /У.Оюунтүлхүүр/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

1

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторын 2021
оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/хх,
тоот тушаалын хавсралт

4417144353
ЕНОА0056 9025707


“Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл”
сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгсөн
албан шаардлагын жагсаалт

Д/д	Албан шаардлагын дугаар	Албан шаардлагын агуулга	Мөнгөн дүн /сая.төгрөг/	Хэрэгжүүлэх албан тушаалтан
1	75/A1070299 ДГА-2021/76-ШТА-ГА	Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай	77.1	Аймгийн СТСХ-ийн дарга Ц.Содхүү Аймгийн СТСХ-ийн ерөнхий санхүүч Х.Анхчимэг
2	76/A1070299 ДГА-2021/76-ШТА-ГА	Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай	0.8	Дэлгэрэх сумын ЭМТ-ийн дарга Э.Чанцалдулам Дэлгэрэх сумын ЭМТ-ийн нягтлан бодогч Б.Шинэбаяр
3	77/A1070299 ДГА-2021/76-ШТА-ГА	Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай	1.8	Дэлгэрэх сумын ЗДТГ-ыг дарга П.Пүрэвсүрэн Дэлгэрэх сумын ЗДТГ-ыг нягтлан бодогч Н.Чулуунтуяа
4	78/A1070299 ДГА-2021/76-ШТА-ГА	Түлээ нүүрсний үлдэгдлийг шийдвэрлүүлэх тухай	7.3	Улаанбадрах сумын Засаг дарга Г.Ганбүрэн Улаанбадрах сумын СА-ны дарга Т.Алтанцэцэг
5	79/A1070299 ДГА-2021/76-ШТА-ГА	Түлээ нүүрсний үлдэгдлийг шийдвэрлүүлэх тухай	1.6	Хатанбулаг сумын Засаг дарга С.Эрдэнэболд Хатанбулаг сумын СА-ны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Чаминчулуун
6	80/A1070299 ДГА-2021/76-ШТА-ГА	Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай	2.1	Өргөн сумын Соёлын төвийн дарга Б.Мөнхбаатар Өргөн сумын Соёлын төвийн нягтлан бодогч С.Баатарсүрэн
7	81/A1070299 ДГА-2021/76-ШТА-ГА	Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай	0.8	Хатанбулаг сумын ЭМТ-ийн дарга Ө.Одсүрэн Хатанбулаг сумын ЭМТ-ийн нягтлан бодогч Ж.Ганбаяр
8	82/A1070299 ДГА-2021/76-ШТА-ГА	Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай	0	Аймгийн СТСХ-ийн дарга Ц.Содхүү Аймгийн СТСХ-ийн ерөнхий санхүүч Х.Анхчимэг
Нийт дүн			91.5	

-----oOo-----

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :


Ахлах аудитор:  Э.Энхцэцэг

Аудитор:  Ч.Хэрлэнчимэг

Аудитор:  Б.Ариунбаатар

ХЯНАСАН:

Аудитын менежер:  У.Оюунтүлхүүр

Дарга, тэргүүлэх аудиторовн
үүргийг түр орлон гүйцэтгэгч:  Т.Ган-Өлзий

**АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.**